



СОЁЛЫН ЯАМ

СОЁЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

УЛААНБААТАР ХОТ, 2021

АГУУЛГА

Зураг, хүснэгтийн жагсаалтууд

Нэг. Салбарын өнөөгийн байдал

Хоёр. Салбарын нөхцөл байдлын шинжилгээ

Гурав. Соёлын бодлого, эрх зүйн орчны үнэлгээ

Дөрөв. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ

Тав. Соёл, урлагийн байгууллагын өнөөгийн байдлын үнэлгээ

Зургаа. Монгол хэрэглэгчийн зан төлөв, хандлагын үнэлгээ

Ашигласан материалууд

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТУУД

Зургийн жагсаалтууд:

Зураг 1.1. Соёл, урлагийн салбарын улсын урсгал төсвийн санхүүжилт	10
Зураг 1.2. Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо.....	11
Зураг 1.3. Урлагийн байгууллагын тоглолт ба үзэгчийн тоо (мян.хүн).....	14
Зураг 1.4. Музейн үзмэрийн тоо ба үзэгчдийн тоо (мян.хүн).....	14
Зураг 1.5. Соёлын төв, ордны суудлын тоо ба үйлчлүүлэгчийн тоо (мян.хүн).....	15
Зураг 1.6. Номын сангийн фонд ба уншигчийн тоо (мян.хүн).....	15
Зураг 3.1. Соёлын бодлогын хэрэгжилтийн байдлын хамаарал	70
Зураг 3.2. Соёлын бодлогын хэрэгжилтийг сайжруулахад анхаарах асуудал, хувиар	71
Зураг 3.3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ.....	73
Зураг 3.4. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжих боломжийн хөндлөнгийн үнэлгээ	74
Зураг 5.1. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамж, хувиар	101
Зураг 5.2. Инноваци, бүтээлч байдалд хандах хандлага, хувиар	101
Зураг 5.3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавхын үнэлгээ	103
Зураг 5.4. Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний соёлын үнэлгээ.....	104
Зураг 5.5. Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийн үнэлгээ	105
Зураг 5.6. Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанарын үнэлгээ	105
Зураг 5.7. Ажиллагчдын ур чадвар, хандлагын үнэлгээ	111
Зураг 6.1. Хүн амын амралт чөлөөт цагаа өнгөрүүлдэг байдал (давхардсан тоогоор),хувиар.....	112
Зураг 6.2. Хүн амын нэг удаагийн амралт, чөлөөт цагийн үйлчилгээнд дунджаар зарцуулдаг мөнгө (мян.төг), хувиар.....	113
Зураг 6.3. Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлдэг давтамж, хувиар	113
Зураг 6.4. Сонирхдог соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүд (давхардсан тоогоор), хувиар.....	114
Зураг 6.5. Судалгаанд оролцогчдын мэдээлэл авдаг эх үүсвэр (давхардсан тоогоор), хувиар.....	114

Зураг 6.6. Ихэвчлэн үйлчлүүлдэг соёл урлагийн байгууллага (давхардсан тоогоор), хувиар.....	115
Зураг 6.7. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан (давхардсан тоогоор), хувиар	116
Зураг 6.8. Судалгаанд оролцогчдын ургийн овгоо сонгосон байдал	116
Зураг 6.9. Судалгаанд оролцогчдын өөрөөсөө дээш хэдэн үе мэддэг байдал .	117
Зураг 6.10. Угийн бичиг хөтөлдөг байдал	117
Зураг 6.11. Хуримын ач холбогдол.....	117
Зураг 6.12. Гэрлэлтийн байдал.....	118
Зураг 6.13. Гэр бүлийн хамгийн эрхэм зүйл.....	118
Зураг 6.14. Өдөрт ямар төрлийн нэвтрүүлэг үздэг эсэх.....	119
Зураг 6.15. Эцэг, эхтэйгээ ямар холбоотой байдаг эсэх.....	119
Зураг 6.16. Гэр бүлээсээ салсан шалтгаан.....	120
Зураг 6.17. Ямар төрлийн хоол түлхүү хэрэглэдэг	121
Зураг 6.18. Баяр ёслол, тэмдэглэлт өдрөөр хаана, ямар хоол иддэг	121
Зураг 6.19. Мэндлэх ёсноос хэвшсэн байдал	122
Зураг 6.20. Цээрлэх ёсноос мөрддөг эсэх	122
Зураг 6.21. Насан өөд болоход хойдохынх ажлыг ямар зан үйлээр хийдэг	123
Зураг 6.22. Хүүхдээ хүмүүжүүлэхдээ ардын аман зохиол, сургаалуудын төрлүүдээс ашигладаг байдал.....	123
Зураг 6.23. Ихэвчлэн тоглуулдаг тоглоом.....	124
Зураг 6.24. Үндэсний дээл хувцсыг ямар үед хэрэглэгдэг болох	124
Зураг 6.25. Цагаан сарын тэмдэглэх нь чухал эсэх.....	124

Хүснэгтийн жагсаалтууд:

Хүснэгт 1.1. Салбарын тоо мэдээлэл.....	6
Хүснэгт 1.3. Соёл, урлагийн байгууллагын тоо	11
Хүснэгт 1.4. СУБ-ын ажиллагчдын боловсролын байдал, хувиар	12
Хүснэгт 1.5. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо, мян.хүн.....	12
Хүснэгт 1.6. Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд	13
Хүснэгт 2.1. Оролцогч талын шинжилгээний ажлын хүснэгт.....	17

Хүснэгт 2.2. Асуудал, хэрэгцээний шинжилгээний ажлын хүснэгт	19
Хүснэгт 2.3. Асуудлын шалтгаан тодорхойлох ажлын хүснэгт	24
Хүснэгт 2.4. Асуудлын үр дагаврыг тодорхойлох ажлын хүснэгт	38
Хүснэгт 2.5. Бодлого зохицуулалтын шинжилгээний ажлын хүснэгт	48
Хүснэгт 2.6. Нөхцөл байдлын нэгтгэсэн шинжилгээ хийх ажлын хүснэгт	60
Хүснэгт 3.1. Үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрийн Засгийн газар болон хөндлөнгийн үнэлгээний харьцуулалт	72
Хүснэгт 3.2. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	80
Хүснэгт 3.3. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	83
Хүснэгт 3.4. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	84
Хүснэгт 3.5. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	86
Хүснэгт 3.6. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	87
Хүснэгт 3.7. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл ..	88
Хүснэгт 4.1. Улс орны хөгжилд үзүүлэх нөлөөллийн харьцуулсан үнэлгээ.....	92
Хүснэгт 4.2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд салбаруудын хөгжлийн эрчимжилт	93
Хүснэгт 4.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлууд	94
Хүснэгт 4.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүд ...	95
Хүснэгт 4.5. Соёл, урлагийн байгууллагуудад зохиогчийн эрхийн зөвшөөрөл авдаг байдал, хувиар	96
Хүснэгт 4.6. Соёл, урлагийн байгууллагуудад зохиогчийн эрхэд роляти төлдөг байдал, хувиар.....	97
Хүснэгт 4.7. Судалгаанд хамрагдагчдын зохиогчийн эрхийн талаарх ойлголт, хувиар.....	97
Хүснэгт 4.8. Зохиогчийг эрхийн зөрчил үүсэж буй шалтгаан, хувиар	98
Хүснэгт 5.1. Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар.....	99
Хүснэгт 5.2. Ажлын байрны орчин нөхцөлийн үнэлгээ, хувиар	100
Хүснэгт 5.3. Хөдөлмөрийн харилцааны үнэлгээ, хувиар	102
Хүснэгт 5.4. СУБ-д мэргэшсэн хүний нөөцийн тогтвортой ажиллах нөхцөл, хувиар.....	106

Хүснэгт 5.5. СУБ-д мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэхэд тулгардаг бэрхшээл, хувиар.....	107
Хүснэгт 5.6. СУБ-аас мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хамтын ажиллагааны хэлбэрүүд (давхардсан тоогоор), хувиар.....	108
Хүснэгт 5.7. СУБ-ын ажиллагчид сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэлт, хувиар	108
Хүснэгт 5.8. СУБ-ын ажиллагчид мэргэжил дээшлүүлэхэд тулгардаг бэрхшээл, хувиар.....	109
Хүснэгт 5.9. СУБ-ын ажиллагчдын сургалтын хэрэгцээ (давхардсан тоогоор), хувиар.....	110

СОЁЛЫН САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Даяаршил, техник технологийн хурдацтай хөгжил, хотжилтын нөлөөгөөр суурин соёл иргэншил хүчтэй түрж, хүн амын амьдралын хэв маяг хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед үндэсний соёлоо дээдлэн уламжлах, шинэчлэлийг шингээх замаар Монгол хүнийг хөгжүүлэхэд төрөөс анхаарлаа хандуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улс “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-оо улс төр, эдийн засаг, нийгмийн хүрээнд хамгийн сүүлд 2012 онд дахин шинэчлэн тодорхойлж, Улсын Их Хурлаар батлуулсан билээ.

Соёлын салбарын эрх зүйн байдлын хувьд гэвэл “Соёлын тухай” (1996 он, 2021 онд шинэчилсэн найруулга), “Соёлын өвийг хамгаалах тухай” (2001 он, 2014 онд шинэчилсэн найруулга), “Номын сангийн тухай” (2014 он), “Монгол хэлний тухай” (2015 он), “Музейн тухай” (2021 он), “Кино урлагийг дэмжих тухай” (2021 он) зэрэг шууд хамаарах хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Мөн салбарын тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг хангах, улс орны нийгэм-эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, үндэсний түүх, соёлын өвөө хадгалж, хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах I, II”, “Ардын уламжлалт урлагийг дэмжих”, “Сонгодог урлаг I, II”, “Морин хуур, уртын дуу”, “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах”, “Монгол хөөмий”, “Монголын уламжлалт бий, биелгээ” “Монгол цуур”, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-I” зэрэг үндэсний хөтөлбөрүүд хэрэгжсэн бөгөөд одоогоор Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр (2018-2022), Монгол уран бүтээл хөтөлбөр (2015-2025), Соёлын биет бус өвийг хамгаалах хөтөлбөр (2019-2023), Сонгодог урлаг III хөтөлбөр (2018-2023), Чулуун соёлын өв үндэсний хөтөлбөр (2019-2024), Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2019-2023) зэрэг үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим соёл”, “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Сонгодог урлаг III”,

“Соёлын бүтээлч үйлдвэрлэл II”, “Монгол өв да дэлхий дахин” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгагдсан болно.

2020 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт төрийн өмчийн урлагийн байгууллага 34, музей 38, номын сан 26, соёлын төв, ордон 346, киноны байгууллага 38 үйл ажиллагаа явуулж, 7,318 соёл мэргэжилтэн, уран бүтээлчид төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагад ажиллаж байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагаа хязгаарлагдсанаар үйлчлүүлэгчдийн тоо 27 хувиар, харин тоглолт, үзвэр, үйлчилгээний тоо 55 хувиар тус тус буурсан байна.

Монгол Улсын Засгийн газраас өнөөдрийн байдлаар 778 дурсгалт зүйлийг Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалаар баталсан бөгөөд 197 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг улсын хамгаалалтад бүртгэсэн байдаг. Мөн 597 түүх, соёлын дурсгал нь аймаг, нийслэлийн хамгаалалтад байна. Түүнчлэн Дэлхийн байгаль, соёлын өвийн жагсаалтад 2003 онд Увс нуурын ай сав газрыг, 2004 онд Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг, 2011 онд Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор, 2015 онд Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг, 2017 онд Дагуурын ландшафтыг тус тус бүртгүүлсэн.

ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад Монгол Улсаас “Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол ардын уртын дуу”, “Монгол хөөмэй”, “Монгол үндэсний уламжлалт баяр наадам”, “Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх”, “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл”, “Монгол шагайн харваа”, “Хөхүүрийн айраг исгэх уламжлал, холбогдох зан үйл”-ийг, харин яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн жагсаалтад “Монгол тууль”, “Монголын уламжлалт бүжиг-бий, биелгээ”, “Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол лимбэчдийн уртын дуу хөгжимдөх уламжлалт арга барил–битүү амьсгаа”, “Монгол уран бичлэг”, “Ингэнд ботго авхуулах зан үйл, “Уул овоо тахих Монгол зан үйл”-ийг тус тус бүртгүүлж тунхаглуулав.

Улсын Үндэсний номын санд нийт 1,5 сая орчим ном судар, “Дорно дахины ном, хэвлэлийн сан хөмрөг”-т манж, хятад, япон, солонгос зэрэг хэлээр туурвисан 100 гаруй мянган соёлын баримтат өв хадгалагдаж байгаагаас Монгол Улсын хосгүй үнэт дурсгал Лувсанданзангийн “Алтантовч”, “Монгол Шунхан Данжуур”,


“Есөн эрдэнийн Ганжуур”, “Сахиусан Дара эх”-ыг ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрт бүртгүүлсэн.

Хүснэгт 1.1. Салбарын тоо мэдээлэл

№	Ангилал	2016	2017	2018	2019	2020	2021
1	ДНБ, тэрбум.төг	93.3	107.5	113.2	136.3	153.6	-
2	ДНБ-д эзлэх хувь	0.4	0.4	0.4	0.4	0.4	
3	Салбарын ДНБ-ий өсөлт, бууралт хувиар	0.7	9.0	2.1	5.0	-1.2	-
4	Хувийн хэвшлийн нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь	15.5	23.4	23.4	22.8	18.7	-
5	Улсын төсвийн санхүүжилт	59.0	60.1	62.5	21.5	36.4	79.4
6	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	13.5	15.1	35	82.2	144.3	102.8
7	Нийт улсын төсвийн хөрөнгө оруулалтад эзлэх хувь	1.38	2.11	5.31	5.27	10.84	7.40
8	Их засвар	0.5	4.2	-	-	5.4	6.1
9	Тоног төхөөрөмж	0	1.0	1.0	1.0	1.3	17.2
10	Улсын нэгдсэн төсвийн зардалд соёл, урлагийн салбарын зардлын эзлэх хувь	0.6	0.9	1.0	1.1	1.6	1.4
11	Урлагийн байгууллага	36	36	35	34	34	-
12	Музей	45	45	46	38	38	-
13	Номын сан	26	26	26	26	26	-
14	Соёлын төв, ордны номын сангийн танхим	336	336	336	338	339	-
15	Соёлын төв, ордон	346	346	345	345	346	-
16	Кино театр	-	-	-	16	15	-
17	Салбарын ажиллагчдын тоо	7,140	7,005	7,041	7,202	7,318	-

№	Ангилал	2016	2017	2018	2019	2020	2021
18	Нийт ажиллах хүчинд эзлэх хувь	0.56	0.52	0.52	0.57	0.57	-
19	Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчид, мян.хүн	9,678.6	9,891.1	12,350.3	9,334.8	6,824.1	-
20	Урлагийн байгууллагын тоглолт	5,204	4,740	4,094	3,711	1,462	-
21	Музейн үзмэр	281,107	276,143	289,589	244,918	246,971	-
22	Номын фонд, мян.ширхэг	6,356.9	6,261.1	6,281.8	6,204.6	6,275.6	-
23	Соёлын төвийн суудал	90,403	88,856	88,007	89,317	90,538	-
24	Үйлдвэрлэсэн кино	59	67	12	49	23	-

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар соёл, урлагийн салбарт нийт 180.7 тэрбум төгрөг үүнээс 36.4 тэрбум төгрөг нь урсгал төсөв, 144.3 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан нь дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/-ний 0.4%, улсын төсвийн орлогын 1.5%-ийг эзэлж байна. Өнгөрсөн оноос салбарын төсөв 77.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажилд 62.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, урсгал төсөв 14.9 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.



Зураг 1.1. Соёл, урлагийн салбарын улсын урсгал төсвийн санхүүжилт

Соёл, урлагийн байгууллагын зарим үзүүлэлтийн өөрчлөлтийг 2005 оноос хойш 5 жилийн давтамжтайгаар авч үзвэл дараах үзүүлэлттэй байна. Соёл, урлагийн байгууллагын тоог 2005 онтой харьцуулахад 31.1%-иар, 2010 онтой харьцуулахад 16.9%-иар, 2015 онтой харьцуулахад 16.5%-иар, өмнөх онтой


харьцуулахад 6.3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Харин 2020 оныхтой харьцуулахад музей, номын сан, соёлын төв, ордны тоо өсөж, киноны байгууллагын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.2. Соёл, урлагийн байгууллагын тоо

№	Үзүүлэлт	2005	2010	2015	2020
1	Урлагийн байгууллага	33	36	36	34
2	Музей	45	41	45	38
3	Номын сан	283	373	370	365
4	Соёлын төв, ордон	338	341	341	346
5	Киноны байгууллага	33	30	32	38*
		732	821	824	821

Тайлбар: * - Киноны байгууллагын тоонд кино театр 15, кино үйлдвэрлэлийн 23 байгууллага орсон. 2019 оны тоонд 163 кино цэг орсон бөгөөд 2020 онд эдгээрээс 26 цэг соёлын төвд ажилласан тул байгууллагын тоонд ороогүй болно.

Соёл, урлагийн салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар төрөөс бодлогоор дэмжиж ирсэн. 1991 онд соёл, урлагийн байгууллагуудад 3,063 хүн ажиллаж байжээ. Харин 2020 онд улсын хэмжээнд 7318 хүн ажиллаж байгаагаас урлагийн байгууллагад 38%, музейд 9%, нийтийн номын санд 7.0%, соёлын төв, ордонд 37%, кино үзвэрийн байгууллагад 9%, бусад байгууллагад 1.0% нь тус тус ажиллаж буй нь улсын хэмжээний ажиллах хүчний 0.57 хувийг бүрдүүлж байна.



Зураг 1.2. Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо

Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тоо 5 жил тутамд өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2019 оны урлагийн байгууллагын ажиллагчдын тоог 2015 онтой харьцуулахад 0.5%, 2010 онтой харьцуулахад 1.7%, 2005 онтой харьцуулахад 37.0%-иар өссөн байна. 2019 онд номын санд ажиллагчдын тоог 2015 онтой харьцуулахад 10.7%-иар буурсан үзүүлэлттэй. Киноны байгууллагад 2020 онд ажиллагчдыг 2015 онтой харьцуулахад 369 хүнээр буюу 124.2%-иар нэмэгдсэн нь соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын тооны өсөлтөд киноны байгууллагад ажиллагчдын тоо нөлөөлсөн гэж үзэж болохоор байна.

Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын боловсролын түвшний хувьд 9.6 хувь нь магистр, доктор ба өмнөх оноос 0.9 хувиар өссөн, 48.4 хувь нь бакалавр ба өмнөх оноос 4.7 хувиар өссөн, 17.4 хувь нь дипломын боловсролтой ба өмнөх оноос 0.1 хувиар буурсан, 24.6 хувь нь дунд боловсролтой ба өмнөх оноос 5.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1.3. СУБ-ын ажиллагчдын боловсролын байдал, хувиар

№	Байгууллага	Доктор, магистр	Бакалавр	Диплом	Дунд
1	Номын сан	11.0	52.6	14.8	21.6
2	Музей	17.8	41.6	17.9	22.7
3	Соёлын төв ордон	3.1	36.5	23.3	37.1
4	Урлагийн байгууллага	6.8	61.9	13.6	17.7
Улсын дундаж		9.6	48.4	17.4	24.6

Соёл, урлагийн байгууллагуудын боловсролтой ажиллагчдын хангалт аймгуудын хувьд харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагдсан.

Соёл, урлагийн байгууллагаар 2020 онд 6,824.1 мян.хүн үйлчлүүлсний 39.6 хувь нь урлагийн байгууллагын үзэгчид, 32.6 хувь нь соёлын төв, ордны үзэгчид, 18.7 хувь нь киноны үзэгчид, 4.9 хувь нь музейн үзэгчид, 4.0 хувь нь нийтийн номын сангийн байнгын уншигчид байна.

Хүснэгт 1.4. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо, мян.хүн

№	Үзүүлэлт	2005	2010	2015	2020
---	----------	------	------	------	------

1	Урлагийн байгууллага	993.2	1,936.6	4,642.7	2,702.9
2	Музей	343.8	416.0	583.4	336.9
3	Номын сан	205.8	297.3	263.2	277.1
4	Соёлын төв, ордон	3,236.1	4,565.2	5,485.7	2,228.4
5	Киноны байгууллага	548.8	1,050.7	1,727.8	1,279.0
	Нийт дүн	5,327.7	8,265.8	12,702.8	6,824.1


2020 оны үйлчлүүлэгчдийн тоон үзүүлэлт (6,8 сая)-ийг 2015 оны үзүүлэлт (12,7 сая)-тэй харьцуулахад урлагийн байгууллагын үзэгчдийн тоо 46.3%-иар буурсан нь цар тахлын улмаас үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбоотой. Соёл, урлагийн байгууллагын нийт үйлчлүүлэгчдийн 66.3 хувь нь соёл, урлагийн тоглолтыг үзэгчид, 33.7 хувь нь бусад олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдагчид байна.

Хүснэгт 1.5. Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	2005	2010	2015	2020
1	Номын сангийн фонд (мян)	6,961.9	6,791.9	6,592.4	6,275.6
2	Номын сангийн суудлын тоо	8,248	10,480	10,694	10,521
3	Музейн үзмэрийн тоо (мян)	204.7	236.6	267.0	247.0
4	Урлагийн байгууллагын тоглолт	3,657	4,947	4,442	1,462
5	Соёлын төвийн суудлын тоо	71,334	87,940	92,334	90,538


Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны зарим үзүүлэлтийг харьцуулан авч үзвэл номын сангийн фонд 2005 оноос хойш буурсан харин суудлын тоо 5 жил тутамд нэмэгдэж ирсэн боловч 2020 оны үзүүлэлтийг 2015 оныхтой харьцуулахад 174-өөр буурсан, музейн үзмэрийн тоо 2005, 2010, 2015 онуудад өссөн, харин 2020 оны үзүүлэлтийг 2015 оныхтой харьцуулахад 20.000 мянгаар буурсан байна.

Урлагийн байгууллага: Манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн эхэн үе буюу 1991 онд улсын хэмжээнд (Улаанбаатар хот, бүх аймгийн төвүүдэд) 28 урлагийн байгууллага үйл ажиллагаа явуулж, нийтдээ 2,554 хүн (салбарын ажиллагчдын 83.3%) ажиллаж, жилдээ давхардсан тоогоор 2,562.2 мян.хүнд (нийт үйлчлүүлэгчдийн 83.3%) үйлчилж байжээ. Харин 2020 онд улсын хэмжээнд 34 урлагийн байгууллага жилдээ 1462 удаагийн тоглолт зохион байгуулж, давхардсан тоогоор 2,702.90 мян.хүнд үйлчилжээ. 2020 оны үзэгчийн тоог 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад 1,939.8 мян. үзэгчээр буурсан байна.



Зураг 1.3. Урлагийн байгууллагын тоглолт ба үзэгчийн тоо (мян.хүн)

Музей: 1991 онд улсын хэмжээнд (Улаанбаатар хот, бүх аймгийн төвүүдэд) 38 музей үйл ажиллагаа явуулж, жилдээ 509.2 мян.хүнд (нийт үйлчлүүлэгчдийн 16.6%) үйлчилж байжээ. Харин 2020 онд улсын хэмжээнд 38 музей үйл ажиллагаа явуулж байгаагаас аймаг, орон нутагт 24 (68.4%), Улаанбаатар хотод 10 (31.6%) музей ажиллаж 244.9 мян.ширхэг үзмэр хадгалагдаж, жилдээ 689.3 мян.хүнд үйлчилжээ.




Зураг 1.4. Музейн үзмэрийн тоо ба үзэгчдийн тоо (мян.хүн)

Музейн үзэгчид таван жил тутам өссөн үзүүлэлттэй харин үзмэрийн тоо 2010, 2015 онд өссөн үзүүлэлттэй боловч 2020 онд буурсан үзүүлэлттэй


харагдаж байна. 2020 оны үзэгчдийн тоог 2015 оны үзүүлэлттэй харьцуулахад 15.3 хувиар өссөн, харин 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад 39.6 хувиар, 2005 оны үзүүлэлттэй харьцуулахад 50 хувиар тус тус өссөн байна.

Соёлын төв, ордон: 1991 онд улсын хэмжээнд (Улаанбаатар хот, сумын төвүүдэд) 330 соёлын төв, ордон үйл ажиллагаа явуулж байжээ. 2020 оны байдлаар 346 соёлын төв, ордон үйл ажиллагаа явуулж, жилдээ 2,228.4 мян.хүнд үйлчилжээ. Нийт үйлчлүүлэгчдийн 56 хувь нь урлагийн тоглолт, 44 хувь нь бусад олон нийтийн үйлчилгээнд хамрагдсан байна.



Зураг 1.5. Соёлын төв, ордны суудлын тоо ба үйлчлүүлэгчийн тоо (мян.хүн)

Нийтийн номын сан: 1990 онд улсын хэмжээнд (Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд) 421 номын сан ажиллаж байсан бөгөөд 2000 онд 281 болж 33.3 хувиар буурсан ба түүнээс хойш тасралтгүй өсжээ. 2020 оны байдлаар 365 номын сан /соёлын төв, ордон ороод/-д 6275.6 мян.ном, хэвлэмэл материал хадгалагдаж, жилдээ 277.1 мянган байнгын уншигч үйлчлүүлжээ.



Зураг 1.6. Номын сангийн фонд ба уншигчийн тоо (мян.хүн)

Монгол Улсын соёл, урлагийн байгууллагуудын дийлэнх хувийг аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн номын сан, соёлын төв, ордон

эзэлж байна. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн 10 жилд тогтмол өсөж байгаа бөгөөд үзэгчдийн дийлэнх нь урлагийн байгууллага, соёлын төв, ордноор үйлчлүүлэгчид байна. Соёлын төв, номын сан, музейн тоо тогтвортой байгаа ч суудлын тоо хэлбэлзэлтэй, музейн үзмэр, үзэгчдийн тоо, номын сангийн фондын хэмжээ буурч байгаа зэрэг нь санхүүжилт, хөрөнгө оруулалт, цар тахлын нөхцөл байдал, байгууламжийн засвар үйлчилгээ зэрэг шалтгаантай холбоотой байна.

Түүнчлэн соёл, урлагийн салбарын статистик мэдээлэл бүрдүүлэлт хэт ерөнхий, салбарын хувийн хэвшлийн үйл ажиллагааг бүртгэдэггүйгээс салбарын хөгжлийн нөхцөл байдлыг цогцоор үнэлэхэд хүндрэлтэй байдаг. Гэтэл соёлын статистик нь соёлын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан соёл, урлагийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох соёлын үйл ажиллагааг төлөвлөх, хянах, дүн шинжилгээ хийхэд суурь мэдээлэл болдог. Иймд салбарын статистик мэдээлэл бүрдүүлэлтийн тогтолцоог олон улсын аргачлалаар хөгжүүлэх шаардлагатай байна. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого зөвхөн төрийн өмчит соёл, урлагийн байгууллагуудын хүрээнд хэрэгжих байдалтай, салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх асуудлыг төдийлөн анхаарахгүй орхигдуулсан нь салбарт зах зээлийн өрсөлдөөнт байдлыг алдагдуулж, салбарын хөгжлийг зогсонги байдалд оруулах үндсэн нөхцөл болсон байна.

Мөн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох өрсөлдөөний таатай орчин бүрдээгүй, түүний төгс бус хэлбэрүүд бий болсноос байгууллагын удирдлагын зүгээс өргөн хүрээнд инновацийг хэрэгжүүлж, маркетингийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах, дэвшилтэт технологи нутагшуулах, чадварлаг мэргэжилтнүүдийг бэлтгэх, ажиллуулах, өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох байдлаар өрсөлдөх давуу талыг олж авахын төлөө хүчин чармайлт гарган ажиллах явдал хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

ХОЁР. САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Соёлын салбарын нөхцөл байдлын шинжилгээг хийхдээ холбогдох заавар, аргачлалыг баримтлан боловсруулав.

Хүснэгт 2.1. Оролцогч талын шинжилгээний ажлын хүснэгт

№	Оролцогч талын нэр:	Хамрах хүрээ (Үр шим хүртэгч/үйлчилгээ үзүүлэгч/түнш/)
1	Оролцогч 1: Төрийн захиргааны байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч
2	Оролцогч 2: Соёл, урлагийн байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч, улсын хэмжээнд 482* соёл, урлагийн байгууллага байна. /* -статистик мэдээлэл ирүүлсэн байгууллагын тоо/
3	Оролцогч 3: Гэр бүл	Үр шим хүртэгч, улсын хэмжээнд 908,712 өрх байна.
4	Оролцогч 4: Орон нутгийн соёлын байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч
5	Оролцогч 5: Урлагийн байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч, улсын хэмжээнд 34 урлагийн байгууллага байна.
6	Оролцогч 6: Мэргэжлийн холбоод	Үйлчилгээ үзүүлэгч
7	Оролцогч 7: Соёлын ажилтан	Үйлчилгээ үзүүлэгч, улсын хэмжээнд 7,318 соёлын ажилтан байна.
8	Оролцогч 8: Хүүхэд залуучууд	Үр шим хүртэгч, 1,526,426
9	Оролцогч 9: Тусгай хэрэгцээт иргэд	Үр шим хүртэгч, улсын хэмжээнд 105,730 хүүхэд залуучууд байна.
10	Оролцогч 10: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Түнш, улсын хэмжээнд 502 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна.
11	Оролцогч 11: Аялал жуулчлалын байгууллага	Үйлчилгээ үзүүлэгч, улсын хэмжээнд 271 аялал жуулчлалын байгууллага байна.
12	Оролцогч 12: Чөлөөт уран бүтээлчид	Үйлчилгээ үзүүлэгч
13	Оролцогч 13: Креатив компани	Үйлчилгээ үзүүлэгч

14	Оролцогч 14: Өвлөн уламжлагчид	Түнш, улсын хэмжээнд 102 өвлөн уламжлагчид байна.
15	Оролцогч 15: Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид	Үйлчилгээ үзүүлэгч, улсын хэмжээнд 5,665 соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид байна.
16	Оролцогч 16: Менежер, продюсер	Үр шим хүртэгч
17	Оролцогч 18: Студи, продакшн	Үйлчилгээ үзүүлэгч
18	Оролцогч 19: Гадаадад амьдарч байгаа монголчууд	Үр шим хүртэгч, улсын хэмжээнд 571,867 Гадаадад амьдарч байгаа монголчууд байна.

Хүснэгт 2.2. Асуудал, хэрэгцээний шинжилгээний ажлын хүснэгт

Асуудал/хэрэгцээ	Хамрах хүрээ	Баримт, нотолгоо
А1. Соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг үнэлэхэд шаардлагатай статистик мэдээлэл хангалтгүй	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5,665 аж ахуйн нэгж, байгууллага байна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа, СоЯ, ММСГ
А2. Соёлын бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээлэл дутмаг	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
А3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх сул	Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх тааруу (3.24)	"Монгол төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах арга" төслийн тайлан, БСШУЯ, СУИС
А4. Соёл, урлагийн байгууллагад хүн ам гэр бүлээрээ чөлөөт цаг өнгөрүүлэх боломжгүй	Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хангалтгүй (2.63)	Эрхэмтөгс Ж, Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй, 2019
А5. Соёлын биет өв устах эрсдэлтэй	"Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 9,754 дурсгалт газрын 90,043 түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна."	Соёлын өвийн үндэсний төв
А6: Өндөр түвшний мэргэжлийн уран бүтээлчид дутагдалтай	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.

A7. Салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын гүйцэтгэх үүрэг хангалтгүй	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
A8. Монгол Улсын гадаад харилцааны бодлогод соёлын салбарын оролцоо сул	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
A9. Соёл, урлагийн байгууллагууд зохиогчийн эрхийн менежмент хэрэгжүүлэх чадамжгүй	Мэдээлэл байхгүй	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС
A10. Соёлын ажилтнууд ур чадвар нийгмийн хөгжлийн шаардлагыг хангаж чадахгүй	Зохиогчийн эрх гэрээ байгуулдаггүй гэсэн 42.2 хувь, зохиогчийн эрх эзэмшигчдэд огт төлдөггүй, ер нь төлдөггүй гэсэн хариулт 71.4 хувь байна.	"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС
A11. Хүүхэд, залуучуудад түүх, өв соёлоо дээдлэх, хүндэтгэх хандлага төлөвшөөгүй	Сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад 43.6% нь огт хамрагдаж байгаагүй, 27.4% нь нэг удаа хамрагдсан, 11.3% нь хоёр удаа хамрагдсан, 10.5% нь гурван удаа хамрагдсан, 7.2% нь жил бүр хамрагджээ.	Судалгаа хийгдэж байгаагүй.
A12. Соёлын үйлчилгээ авах, соёлын боловсрол хүртэх боломж хязгаарлагдмал	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.

<p>A13. Хүн амын соёл, урлагийн боловсролыг дэмжсэн нэвтрүүлэг, контент дутагдалтай</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>
<p>X1. Соёлын аялал жуулчлалд соёлын байгууллагын оролцоо хангалтгүй</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС</p>
<p>X2. Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн хүний нөөцийн дутагдалтай</p>	<p>Урлагийн байгууллага 34, музей 38, нийтийн номын сан 365, соёлын төв, ордон 346 үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС</p>
<p>X3. Уран бүтээлчид бүтээл туурвилын үр шимийг хүртэж чадахгүй</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын боловсролын түвшний хувьд 9.1% нь доктор, магистр, 43.8% нь бакалавр, 10.8% нь дипломын дээд, 36.3 % нь дунд боловсролтой, нөгөө талаас соёл, урлагийн чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 71% нь Улаанбаатар хотод, 6.4% нь гадаадад ажиллаж амьдардаг.</p>	<p>"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС</p>

Х4. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул	Уран бүтээлчдийн 64.2 хувь нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн талаар ер нь мэдэхгүй, 17.5 хувь огт мэдэхгүй. Талант менежмент мэргэжлийн түвшинд төлөвшөөгүй (2.34) байна.	Эрхэмтөгс Ж, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019
Х5. Соёлын биет бус өв устах эрсдэлтэй	Улсын ДНБ-ий 0.4 хувийг бүрдүүлж байна. Дэлхий дахин соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөө 2013 оны байдлаар 2.3 их наяд ам.доллар байна.	Соёлын өвийн үндэсний төв
Х6. Соёлын өвд суурилсан брэндийн өрсөлдөх чадвар сул	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо 2020 онд 10,849 байна.	Судалгаа хийгдэж байгаагүй.
Х7. Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвүүдийн конвенцын хэрэгжилт сул	Мэдээлэл байхгүй	Соёлын өвийн үндэсний төв
Х8. Урлагийн салбарт талант менежмент хөгжөөгүй	Мэдээлэл байхгүй	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС
Х9. Урлагийн хөгжилд урлаг судлал, шүүмжийн ач холбогдлыг ойлгохгүй	Монгол Улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад 15 өв бүртгүүлсэн.	Судалгаа хийгдэж байгаагүй.
Х10. Соёл, урлагийн салбарт цахим шилжилт удаашралтай	Соёл, урлагийн салбарт талант менежментийн хөгжлийн түвшин сул буюу төлөвшөөгүй (2.34) ба үүнд салбарын инновацийн түншлэл, хамтын ажиллагааг сул (3.00), уран бүтээлчийн манлайлал	Судалгаа хийгдэж байгаагүй.

	хангалтгүй (2.39), уран бүтээлчийн карьер хөгжил сул (1.95), олон улсад уран бүтээл туурвил хангалтгүй (2.45), олон улсад өрсөлдөх чадавх сул (1.92) байна.	
X11. Нийгэмд үндэсний нэгдмэл үнэт зүйлийн талаарх ойлголт муу	Мэдээлэл байхгүй	"Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл" судалгааны тайлан, СУИС
X12: Монгол хэл, соёлын дархлаа суларсан	Мэдээлэл байхгүй.	http://hmc.mn/medee/v/6
X13. Олон улсад Монголын имиж бүрдээгүй	"Нийслэлийн 9 дүүрэг, орон нутгийн	Судалгаа хийгдэж байгаагүй.

Хүснэгт 2.3. Асуудлын шалтгаан тодорхойлох ажлын хүснэгт

Асуудал/хэрэгцээ	Шалтгаан	Хамрах хүрээ	Баримт нотолгоо	Ноцтой байдал	Яаралтай байдал	Эрэмбэ
A1. Соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг үнэлэхэд шаардлагатай статистик мэдээлэл хангалтгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээ гаргадаг, хувийн хэвшлийн цөөн тооны байгууллага мэдээлэл ирүүлдэг	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5,665 аж ахуйн нэгж, байгууллага байна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа, СоЯ, ММСГ	5	5	10
A2. Соёлын бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээлэл дутмаг	Соёлын бодлогын судалгааны байгууллага байхгүй, соёлын бодлогын судлалын мэргэшсэн судлаач хомс, санхүүжилт хангалтгүй	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй	5	5	10
A3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх сул	Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөл хуучирсан, менежмент нь хоцрогдсон, хүний нөөцийн чадавх сул	Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх тааруу (3.24)	"Монгол төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах арга"	4	4	8

			төслийн тайлан, БСШУЯ, СУИС			
A4. Соёл, урлагийн байгууллагад хүн ам гэр бүлээрээ чөлөөт цаг өнгөрүүлэх боломжгүй	Соёл, урлагийн байгууллагын орчин хангалтгүй, үйлчилгээний чанар хангалтгүй, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээг хангадаггүй	Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хангалтгүй (2.63)	Эрхэмтөгс Ж, Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй, 2019	4	4	8
A5. Соёлын биет өв устах эрсдэлтэй байна.	Соёлын биет бус өвийн эрсдэлийн үнэлгээ хийдэггүй, санхүүжилт хангалтгүй, хээрийн болон археологийн судалгаа бараг хийдэггүй, нийгэмд өвийн үнэ цэнийг ойлгуулахад чиглэсэн зорилтот үйл ажиллагаа тогтмол бус, уул уурхайн компаниудад ойлголт байхгүй	Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 9,754 дурсгалт газрын 90,043 түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна.	Соёлын өвийн үндэсний төв	5	4	9

<p>A6: Өндөр түвшний мэргэжлийн уран бүтээлчид дутагдалтай</p>	<p>Соёл, урлагийн хөдөлмөрийн эдийн засгийн эрэлт, нийлэлтийн бодлого байхгүй, шаардлагатай урлагийн мэргэжлээр суралцахыг дэмжсэн тэтгэлэг байхгүй, урлагийн байгууллагын урын сангийн бодлого ба хүний нөөцийн төлөвлөлт уялдаагүй</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>	<p>5</p>	<p>4</p>	<p>9</p>
<p>A7. Салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын гүйцэтгэх үүрэг хангалтгүй</p>	<p>Мэргэжлийн холбоодын менежментийн чадавх сул, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад манлайлан оролцох, нөхцөл байдлыг мэргэшлийн түвшинд үнэлж, Төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах талаар санаачилга байхгүй,</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>	<p>4</p>	<p>3</p>	<p>7</p>

	холбоодын удирдлагууд хувийн эрх ашиг, сонирхлоо чухалчилдаг					
A8. Монгол Улсын гадаад харилцааны бодлогод соёлын салбарын оролцоо сул	Гадаад хамтын ажиллагааны сүлжээнд элсэж ороогүй. Гадаад хэлний өндөр чадвартай ажиллагчид цөөн, төсөв хөрөнгө байхгүй.	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	3	6
A9. Соёл, урлагийн байгууллагууд зохиогчийн эрхийн менежмент хэрэгжүүлэх чадамжгүй	Зохиогчийн эрхийн тухай ойлголт тааруу, төсөв байхгүй, зохиогчийн эрхтэй холбоотой статистик мэдээлэл хомс, хэрхэн хамгаалах арга зам тодорхойгүй. Мэдээллийн эх сургалт хомс.	Зохиогчийн эрх гэрээ байгуулдаггүй гэсэн 42.2 хувь, зохиогчийн эрх эзэмшигчдэд огт төлдөггүй, ер нь төлдөггүй гэсэн хариулт 71.4 хувь байна.	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС	3	3	6
A10. Соёлын ажилтнууд ур чадвар нийгмийн	Төрөөс соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх талаар баримтлах бодлого	Сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэх	"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн	4	4	8

хөгжлийн шаардлагыг хангаж чадахгүй	тодорхойгүй, ажлын орчин нөхцөл тааруу, цалин урамшуулал бага, мэргэжил дээшлүүлэхэд орон нутаг, байгууллагаас эдийн засгийн дэмжлэг байхгүй,	сургалтад 43.6% нь огт хамрагдаж байгаагүй, 27.4% нь нэг удаа хамрагдсан, 11.3% нь хоёр удаа хамрагдсан, 10.5% нь гурван удаа хамрагдсан, 7.2% нь жил бүр хамрагджээ.	байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС			
A11. Хүүхэд, залуучуудад түүх, өв соёлоо дээдлэх, хүндэтгэх хандлага төлөвшөөгүй	Хүүхэд, залуучуудад соёл, урлагийн боловсрол олгоход соёл - боловсролын хамтын ажиллагаа сул, соёлын боловсрол олгох хүрээнд хамтын ажиллагаа байхгүй, Соёлын боловсрол олгох үндэсний хэмжээний хөтөлбөр байхгүй. Сургалтын	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	4	7

	хөтөлбөрт нэгдмэл агуулга байхгүй					
A12. Соёлын үйлчилгээ авах, соёлын боловсрол хүртэх боломж хязгаарлагдмал	Соёл, боловсролын үйлчилгээний байгууллагад тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан орчин нөхцөл, техник тоног төхөөрөмж, бүлгийн онцлогт тохирсон хөтөлбөр, дэмжлэг байхгүй, энэ талын ойлголт төлөвшөөгүй	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	3	6
A13. Хүн амын соёл, урлагийн боловсролыг дэмжсэн нэвтрүүлэг, контент дутагдалтай	Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад тогтоосон хөтөлбөр, эфирт эзлэх соёлын боловсролын агуулгатай контентыг нэвтрүүлэх цаг бага, нийтэд хүргэх санхүүгийн дэмжлэг байхгүй	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	2	2	4

<p>X1. Соёлын аялал жуулчлалд соёлын байгууллагын оролцоо хангалтгүй</p>	<p>Орон нутгийн соёлын байгууллагад олон талт үйлчилгээ байхгүй, бусад салбартай хамтран ажиллах тал дээр санаачлаагүйг, зөвхөн улсын болон орон төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг</p>	<p>Урлагийн байгууллага 34, музей 38, нийтийн номын сан 365, соёлын төв, ордон 346 үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС</p>	<p>1</p>	<p>2</p>	<p>3</p>
<p>X2. Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн хүний нөөцийн дутагдалтай</p>	<p>Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн эрэлт-нийлүүлэлтийн зохицуулалт байхгүй, соёлын ажилтны цалин бага, нийгмийн баталгаа хангалтгүй,</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын боловсролын түвшний хувьд 9.1% нь доктор, магистр, 43.8% нь бакалавр, 10.8% нь дипломын дээд, 36.3 % нь дунд боловсролтой, нөгөө талаас</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУЯ, СУИС</p>	<p>3</p>	<p>4</p>	<p>7</p>

		соёл, урлагийн чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 71% нь Улаанбаатар хотод, 6.4% нь гадаадад ажиллаж амьдардаг.				
Х3. Уран бүтээлчид бүтээл туурвилын үр шимийг хүртэж чадахгүй	Уран бүтээлчдэд зохиогчийн эрхийн талаар ойлголт хангалтгүй, урлагийн менежмент хийх туршлага сул, мэргэшсэн менежер, продюсер байхгүй	Уран бүтээлчдийн 64.2 хувь нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн талаар ер нь мэдэхгүй, 17.5 хувь огт мэдэхгүй. Талант менежмент мэргэжлийн түвшинд	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС	2	3	5

		төлөвшөөгүй (2.34) байна.				
X4. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул	Кретив компани хөрөнгө оруулалт татах боломжгүй, төрөөс дэмжлэг байхгүй, олон улсын зах зээлд өрсөлдөх үндэсний брэндийн нэгдсэн бодлого байхгүй	Улсын ДНБ-ий 0.4 хувийг бүрдүүлж байна. Дэлхий дахин соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөө 2013 оны байдлаар 2.3 их наяд ам.доллар байна.	Эрхэмтөгс Ж, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019	2	2	4
X5. Соёлын биет бус өв устах эрсдэлтэй	Өвлөн уламжлагчдыг дэмжлэг, урамшуулал хангалтгүй, соёлын биет бус өвийг судлах, баримтжуулах, сан бүрдүүлэх ажил удаашралтай, өвлөн уламжлагчид өөрсдийн ур	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо 2020 онд 10,849 байна.	Соёлын өвийн үндэсний төв	4	2	6

	чадвараар хөдөлмөр эрхлэх, жижиг бизнес эрхлэх болон үр шимийг нь хүртэх ойлголт байхгүй,					
Х6. Соёлын өвд суурилсан брэндийн өрсөлдөх чадвар сул	соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн чадавх сул, соёлын өвд суурилсан брэнд хөгжүүлэх туршлага бага, үндэсний брэндийн нэгдсэн бодлого байхгүй,	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	3	6
Х7. Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвүүдийн конвенцын хэрэгжилт сул	ЮНЕСКО-ийн Дэлхийн өв болон Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтыг тус Конвенциудын үзэл баримтлалын дагуу хангахад хүндрэл учирч байна.ЮНЕСКО-ийн Дэлхийн өв болон Соёлын биет бус өвийн жагсаалтад	Монгол Улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад 15 өв бүртгүүлсэн.	Соёлын өвийн үндэсний төв	2	2	4

	нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оролцогч талуудын оролцоо дутмаг, хангалтгүй байна.					
Х8. Урлагийн салбарт талант менежмент хөгжөөгүй	Талант менежментийн талаар ойлголт хангалтгүй, өнгөц байдлаар ханддаг, урлагийн байгууллагуудыг менежментийн суурь ойлголтгүй хүмүүс удирддаг, бизнесийн зарчмаар ажиллах арга барил эзэмшээгүй	Соёл, урлагийн салбарт талант менежментийн хөгжлийн түвшин сул буюу төлөвшөөгүй (2.34) ба үүнд салбарын инновацийн түншлэл, хамтын ажиллагааг сул (3.00), уран бүтээлчийн манлайлал хангалтгүй (2.39), уран бүтээлчийн карьер хөгжил сул	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС	3	2	5

		(1.95), олон улсад уран бүтээл туурвил хангалтгүй (2.45), олон улсад өрсөлдөх чадавх сул (1.92) байна.				
X9. Урлагийн хөгжилд урлаг судлал, шүүмжийн ач холбогдлыг ойлгохгүй	Урлаг судлалыг төрөөс дэмжих бодлого, уран бүтээлчид уран бүтээлд нь мэргэжлийн шүүмж өгөхөөс айдаг, тайз, дэлгэц дээр тоглогдох бүтээлд мэргэжлийн талаас шүүмж өгөх соёл төлөвшөөгүй	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	3	6
X10. Соёл, урлагийн салбарт цахим шилжилт удаашралтай	Санхүүжилт хүрэлцээгүй, нарийн мэргэжилтэн бэлтгэгдээгүй. Орчин нөхцөл тааруу.	Мэдээлэл байхгүй.	Судалгаа хийгдэж байгаагүй.			
X11. Нийгэмд үндэсний нэгдмэл	Монголчууд уламжлалт ёс заншил, түүхийн талаарх	Нийслэлийн 9 дүүрэг, орон	"Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт	3	2	5

<p>үнэт зүйлийн талаарх ойлголт муу</p>	<p>соёлын боловсрол олгох тогтолцоо тодорхой биш, шинжлэх ухааны үндэслэл тодорхойлох талаар санаачилга байхгүй, бусдын хийсэн зүйлийг хүлээн зөвшөөрдөггүй</p>	<p>нутгийн 11 аймгаас 1500 хүнээс анкетын болон 85 хүнээс фокус бүлгийн ярилцлага, уран бүтээлчдийн чөлөөт ярилцлага, шинжээчийн ганцаарчилсан ярилцлага хийж есөн үнэт үйл тодорхойлсон.</p>	<p>зүйл" судалгааны тайлан, СУИС</p>			
<p>X12: Монгол хэл, соёлын дархлаа суларсан</p>	<p>Төрийн зүгээс гадаадад амьдарч байгаа монголчуудад Монгол хэл, түүх өв соёлоосоо суралцах боломж олгох санаачилга сул, мэргэшсэн багш</p>	<p>Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан бус мэдээллээр 2019 оны жилийн эцсийн байдлаар</p>	<p>http://hmc.mn/medee/v/6</p>	<p>2</p>	<p>2</p>	<p>4</p>

	бэлтгэгдээгүй, шинжлэх ухааны үндэстэй сургалтын нэгдсэн хөтөлбөр байхгүй, төрөөс ямар нэг дэмжлэг байхгүй	нийт 197.0 мянган иргэн гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байна.				
X13. Олон улсад Монгол Улсын имиж бүрдээгүй	Монголын имиж бий болгох, санаачилга, зохион байгуулалт, мэргэжлийн баг бүрдүүлэлт, санхүүгийн дэмжлэг байхгүй	Мэдээлэл байхгүй.	Судалгаа хийгдэж байгаагүй.	3	3	6

Хүснэгт 2.4. Асуудлын үр дагаврыг тодорхойлох ажлын хүснэгт

Асуудал/хэрэгцээ	Үр дагавар	Үр нөлөө	Хамрах хүрээ	Баримт нотолгоо
A1. Соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг үнэлэхэд шаардлагатай статистик мэдээлэл хангалтгүй	Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр буурна	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5,665 аж ахуйн нэгж, байгууллага байна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа, СоЯ, ММСГ
A2. Соёлын бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээлэл дутмаг	Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй	Соёл, урлагийн салбарын хөгжлийн түвшин, үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр буурна	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
A3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх сул	Хүн ам соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэхээс татгалзах	Соёл, урлагийн байгууллагын нийгэмд эзлэх байр суурь буурна.	Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх тааруу (3.24)	"Монгол төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах арга" төслийн тайлан, БСШУСЯ, СУИС
A4. Соёл, урлагийн байгууллагад хүн ам гэр бүлээрээ чөлөөт цаг өнгөрүүлэх боломжгүй	Хүн ам соёл, урлагийн байгууллагаар	Соёл, урлагийн байгууллагын нийгэмд эзлэх байр суурь буурна.	Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанар хангалтгүй (2.63)	Эрхэмтөгс Ж, Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй, 2019

	үйлчлүүлэхээс татгалзах			
A5. Соёлын биет өв устах эрсдэлтэй байна.	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтыг доройтуулах, тонох, хулгайлах, хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдаалах устгах, сүйтгэх зэрэг бүх төрлийн эрсдэлд орж байна.	Соёлын биет өв устах нь улс үндэстний түүхийн нотолгоо баримт үгүй болно.	Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санд 9,754 дурсгалт газрын 90,043 түүх, соёлын үл хөдлөх дурсгал бүртгэлтэй байна.	Соёлын өвийн үндэсний төв
A6: Өндөр түвшний мэргэжлийн уран бүтээлчид дутагдалтай	Мэргэжлийн уран бүтээл туурвихад хүндрэлтэй болно.	Урлагийн байгууллагууд олон улсад өрсөлдөх чадваргүй болно.	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
A7. Салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын гүйцэтгэх үүрэг хангалтгүй	Салбарын хөгжлийн бодлогын тогтвортой, шинжлэх ухааны үндэслэлтэй байх боломжгүй болно.	Салбарын тогтвортой хөгжил алдагдаж, өрсөлдөх чадвар буурна.	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.

<p>A8. Монгол Улсын гадаад харилцааны бодлогод соёлын салбарын оролцоо сул</p>	<p>Монгол Улсын дүр төрхийг олон улсад соёл, урлагийн илэрхийлэх боломж алдагдана.</p>	<p>Олон улсад Монгол Улсын эзлэх байр суурь суларна.</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>
<p>A9. Соёл, урлагийн байгууллагууд зохиогчийн эрхийн менежмент хэрэгжүүлэх чадамжгүй</p>	<p>Уран бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй болох, уран бүтээлчдийн хувийн өмч үнэгүйднэ.</p>	<p>Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжилд саад болно. Уран бүтээлчид эдийн засгийн үр шимийг хүртэж чадахгүй.</p>	<p>Зохиогчийн эрх гэрээ байгуулдаггүй гэсэн 42.2 хувь, зохиогчийн эрх эзэмшигчдэд огт төлдөггүй, ер нь төлдөггүй гэсэн хариулт 71.4 хувь байна.</p>	<p>"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС</p>
<p>A10. Соёлын ажилтнууд ур чадвар нийгмийн хөгжлийн шаардлагыг хангаж чадахгүй</p>	<p>Соёлын ажилтны нийгмийн баталгаа алдагдана.</p>	<p>Нийгэмд соёлын ажилтны үнэлэмж унаж, мэргэжлийн хүний нөөцийн хомсдол бий болно.</p>	<p>Сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэх сургалтад 43.6% нь огт хамрагдаж байгаагүй, 27.4% нь нэг удаа хамрагдсан, 11.3% нь хоёр удаа хамрагдсан, 10.5% нь гурван удаа хамрагдсан, 7.2% нь жил бүр хамрагджээ.</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУСЯ, СУИС</p>

<p>A11. Хүүхэд, залуучуудад түүх, өв соёлоо дээдлэх, хүндэтгэх хандлага төлөвшөөгүй</p>	<p>Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.</p>	<p>Улс орны соёл иргэншлийн аюулгүй байдал алдагдах.</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>
<p>A12. Соёлын үйлчилгээ авах, соёлын боловсрол хүртэх боломж хязгаарлагдмал</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох, өөрийгөө хөгжүүлэх боломж алдагдана.</p>	<p>Хүний суурь эрх зөрчигдөж, нийгэм тэгш бус байдал бий болно.</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>
<p>A13. Хүн амын соёл, урлагийн боловсролыг дэмжсэн нэвтрүүлэг, контент дутагдалтай</p>	<p>Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.</p>	<p>Улс орны соёл иргэншлийн аюулгүй байдал алдагдах.</p>	<p>Мэдээлэл байхгүй</p>	<p>Судалгаа хийгдэж байгаагүй.</p>
<p>X1. Соёлын аялал жуулчлалд соёлын байгууллагын оролцоо хангалтгүй</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын санхүүгийн чадавх болон өрсөлдөх чадвар буурна</p>	<p>Нийгэм, эдийн засгийн хөгжилд соёл, урлагийн байгууллагын үзүүлэх нөлөөлөл буурна.</p>	<p>Урлагийн байгууллага 34, музей 38, нийтийн номын сан 365, соёлын төв, ордон 346 үйл ажиллагаа явуулж байна.</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУСЯ, СУИС</p>

<p>Х2. Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн хүний нөөцийн дутагдалтай</p>	<p>Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийн хомсдол орно.</p>	<p>Нийгэм, эдийн засгийн хөгжилд соёл, урлагийн байгууллагын үзүүлэх нөлөөлөл буурна.</p>	<p>Соёл, урлагийн байгууллагын ажиллагчдын боловсролын түвшний хувьд 9.1% нь доктор, магистр, 43.8% нь бакалавр, 10.8% нь дипломын дээд, 36.3 % нь дунд боловсролтой, нөгөө талаас соёл, урлагийн чиглэлээр их, дээд сургууль төгсөгчдийн 71% нь Улаанбаатар хотод, 6.4% нь гадаадад ажиллаж амьдардаг.</p>	<p>"Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУСЯ, СУИС</p>
<p>Х3. Уран бүтээлчид бүтээл туурвилын үр шимийг хүртэж чадахгүй</p>	<p>Уран бүтээлчид уран бүтээлээс тогтмол орлого олох боломжгүй.</p>	<p>Уран бүтээлчдийн нийгмийн баталгаа алдагдаж, амьдралын чанар буурна.</p>	<p>Уран бүтээлчдийн 64.2 хувь нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн талаар ер нь мэдэхгүй, 17.5 хувь огт мэдэхгүй. Талант</p>	<p>"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС</p>

			менежмент мэргэжлийн түвшинд төлөвшөөгүй (2.34) байна.	
X4. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр хангалтгүй байна.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн олон улсын зах зээлд гарах, өрсөлдөж чадахгүй.	Улсын ДНБ-ий 0.4 хувийг бүрдүүлж байна. Дэлхий дахин соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын эдийн засагт үзүүлсэн нөлөө 2013 оны байдлаар 2.3 их наяд ам.доллар байна.	Эрхэмтөгс Ж, "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019
X5. Соёлын биет бус өв устах эрсдэлтэй	Соёлын биет бус уусах, уламжлалт мэдлэг мартагдах, устах эрсдэлд орж байна.уламжлалт мэдлэг, туршлага мартагдаж, өвийн оршин тогтнох байдалд шууд эрсдэл үүсэж байна.соёлын биет	Үндэстний соёл иргэншлийн аюулгүй байдал шууд эрсдэлд орно.Соёлын биет бус өв мартагдсан, устсан тохиолдолд сэргээн амилуулах боломжгүй болж, бүрмөсөн устана.соёлын биет	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоо 2020 онд 10,849 байна.	Соёлын өвийн үндэсний төв

	бус өв уусах, мартагдах, соёлын орон зай эзгүйрэх, үнэ цэн, ач холбогдол алдагдах эрсдэл үүсэж байна,	бус өв мартагдаж, устана.		
X6. Соёлын өвд суурилсан брэндийн өрсөлдөх чадвар сул	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн гадаад худалдаа хангалтгүй.	Олон улсад өрсөлдөх чадвартай үндэсний брэнд хөгжихгүй,	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
X7. Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвүүдийн конвенцын хэрэгжилт сул	Конвенцын үзэл баримтлалтай зөрчилдөх эрсдэлтэй.	Монгол Улсын нэр хүнд олон улсад буурах эрсдэлтэй	Монгол Улс 2008 оноос хойш Соёлын биет бус өвийн конвенцын Яаралтай хамгаалах шаардлагатай болон Төлөөллийн жагсаалтад 15 өв бүртгүүлсэн.	Соёлын өвийн үндэсний төв
X8. Урлагийн салбарт талант менежмент хөгжөөгүй	Уран бүтээлчид тогтвортой орлого олж чадахгүй,	Уран бүтээлчдийн бүтээн туурвих эрх чөлөө алдагдаж,	Соёл, урлагийн салбарт талант менежментийн хөгжлийн түвшин сул буюу төлөвшөөгүй (2.34)	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС

	амьдралын чанар сайжрахгүй.	нийгэмд эзлэх байр суурь алдагдана.	ба үүнд салбарын инновацийн түншлэл, хамтын ажиллагааг сул (3.00), уран бүтээлчийн манлайлал хангалтгүй (2.39), уран бүтээлчийн карьер хөгжил сул (1.95), олон улсад уран бүтээл туурвил хангалтгүй (2.45), олон улсад өрсөлдөх чадавх сул (1.92) байна.	
X9. Урлагийн хөгжилд урлаг судлал, шүүмжийн ач холбогдлыг ойлгохгүй	Хүн амын урлагт хандах хандлага буурч, нийгэмд үнэ цэнгүй болно.	Мэргэжлийн урлаг хөгжлийн зогсонги байдалд орж, нийгмийг сайн сайханд дагуулах боломжгүй болно.	Мэдээлэл байхгүй	Судалгаа хийгдэж байгаагүй.
X10. Соёл, урлагийн салбарт цахим шилжилт удаашралтай	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн олон улсын зах зээлд гарах,	Мэдээлэл байхгүй.	Судалгаа хийгдэж байгаагүй.

	нэмэр хангалтгүй байна.	өрсөлдөж чадахгүй.		
X11. Нийгэмд үндэсний нэгдмэл үнэт зүйлийн талаарх ойлголт муу	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Улс орны соёл иргэншлийн аюулгүй байдал алдагдах.	Нийслэлийн 9 дүүрэг, орон нутгийн 11 аймгаас 1500 хүнээс анкетын болон 85 хүнээс фокус бүлгийн ярилцлага, уран бүтээлчдийн чөлөөт ярилцлага, шинжээчийн ганцаарчилсан ярилцлага хийж есөн үнэт үйл тодорхойлсон.	"Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл" судалгааны тайлан, СУИС
X12: Монгол хэл, соёлын дархлаа суларсан	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Улс орны соёл иргэншлийн аюулгүй байдал алдагдах.	Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан бус мэдээллээр 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 197.0 мянган иргэн гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч байна.	http://hmc.mn/medee/v/6

X13. Олон улсад Монголын имиж бүрдээгүй	Монгол Улсын дүр төрхийг олон улсад соёл, урлагийн илэрхийлэх боломж алдагдана.	Олон улсад Монгол Улсын эзлэх байр суурь сулран.	Мэдээлэл байхгүй.	Судалгаа хийгдэж байгаагүй.
---	---	---	-------------------	--------------------------------

Хүснэгт 2.5. Бодлого зохицуулалтын шинжилгээний ажлын хүснэгт

		Алхам 6. Бодлогын шинжилгээ											
		Бодлогын хэрэгжилтийн шинжилгээ					Бодлогын уялдаа/мандатын шинжилгээ						
Асуудал/хэрэгцээ		Баримт бичгийн нэр	Шалгуур үзүүлэлт	1 Сүлж	2 Зорилго	3 Гүйцэтгэ	4 Бодлогы	Товч дүгнэлт	Төрөл/ангил	Нэр	Уялдаа	Оролцогч тал	Чиг үүрэг
Асуудал/хэрэгцээ		Баримт бичгийн нэр	Шалгуур үзүүлэлт	1	2	3	4	5	Төрөл/ангил	Нэр	Уялдаа	Оролцогч тал	Чиг үүрэг
A1. Соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг		"Соёлын үйлдвэрлэл"	8.1.3. Соёлын үйлдвэрлэлийн мэдээлэл, судалгааны нэгдсэн бааз соёл, урлагийн салбарын статистик мэдээлэлд шинээр бий болсон байх;	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулахад оршино.	Бодлогын баримт бичиг	Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	4.2.6.2	Бодлогын хэрэгжилтийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийнхэн	хяналт-шинжилгээ, үнэлгээг ХИЙХ
A2. Соёлын бодлогыг		Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох	Байхгүй	Бодлогын	Төрөөс соёлын	16.1.1	соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн	хяналт, ШИНЖИЛГЭЭ-

<p>A5. Соёлын биет өв устах эрсдэлтэй байна.</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй Тооцох боломжгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Бодлогын баримт бичиг Төрөөс соёлын талаар баримтлах бодлого</p>	<p>4.3.10</p>	<p>Бодлогын хэрэгжилтийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийнхэн</p>	<p>соёлын өвийг судалж, сурталчлах, сэргээн босгох,</p>
<p>A4. Соёл,</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй Тооцох</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй Байхгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй</p>
<p>A3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн</p>	<p>"Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөр</p>	<p>-</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй Тооцох боломжгүй</p>	<p>үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулахад оршино.</p>	<p>Бодлогын баримт бичиг Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого</p>	<p>4.2.6.1</p>	<p>Бодлогын хэрэгжилтийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон хувийн хэвшлийнхэн</p>	<p>хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх</p>
							<p>холбогдох байгууллагууд</p>	

<p>A8. Монгол Улсын "Сонго дог урлаг-III"</p>	<p>3 дугаар бүлгийн 3.2 дахь заалт</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй</p>	<p>Тооцох</p> <p>Сонгодог урлагийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх, салбар хоорондын үр дүнд суурилсан</p>	<p>Хууль</p>	<p>Соёлын тухай хууль</p>	<p>27.1.9</p>	<p>Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын</p>	
<p>A7. Салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын гүйцэтгэх үүрэг хангалтгүй</p>	<p>Байхгүй</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй</p>	<p>Тооцох боломжгүй</p> <p>Байхгүй</p>	<p>Хууль</p>	<p>Соёлын тухай хууль</p>	<p>17.1</p>	<p>Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлага</p>	
<p>A6: Өндөр түвшний мэргэжлийн уран</p>	<p>"Сонго дог урлаг-III" хөтөлбөр</p>	<p>Байхгүй Байхгүй Байхгүй</p>	<p>Тооцох боломжгүй</p> <p>сонгодог урлагийн нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх, салбар хоорондын үр дүнд суурилсан хамтын ажиллагааг хөгжүүлж сонгодог урлагийн тогтвортой хөгжлийг хангах</p>	<p>Үндэсний хөтөлбөр</p>	<p>"Хүний нөөцийн хөгжил"</p>	<p>4.2. 4.3.</p>	<p>Төр, засгийн байгууллага</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжлийн урлагийн байгууллагууд Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, уран бүтээлч, иргэд 	

		хөтөлбөр					хамтын ажиллагааг хөгжүүлж сонгодог урлагийн тогтвортой хөгжлийг хангах				асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлага	
	A9. Соёл, урлагийн байгууллагууд зохиогчийн	"Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөр"	Зохиогчийн эрхийг хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлсэн байдал	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	Үйл ажиллагааны хэрэгжилтээр үнэлнэ.	Хууль	"Оюуны өмчийн тухай"	4.19.4.20.4.21.	МУОӨГ, ХУБ
A10. Соёлын ажилтнууд ур чадвар нийгмийн хөгжлийн	"Соёл урлагийн салбарын хүний нөөцийг	Соёлын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдсан хүний нөөцийн оновчтой бодлогыг системтэйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байгааг онцолсон	Хууль	Соёлын тухай хууль	15.1.6.15.1.8 18.1.5	Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон	

		хөгжүүлэх" хөтөлбөр									нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлага		
4.1	A11. Хүүхэд, залуучуудад түүх, өв соёлоо дээдлэх, хүндэтгэх хандлага төлөвшөөгүй	Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр	Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг тухайн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт тусгасан байдал;	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх ээлтэй орчныг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилготой.	Хууль	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	6.1.1 8.1.3.12.3.3	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Залуучуудын хөгжлийн үндэсний болон салбар зөвлөл	үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах
4.2	A12. Соёлын үйлчилгээ авах,	Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлтэй хүний эрх,	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх, тэдний	7.7	15	Байхгүй	Тооцох боломжгүй	хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн гишүүний хувьд үндсэн эрхээ эдэлж, хөгжих боломжийг өргөн тусгасан	Хууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний	14.1.1 15.1.2	МУ-ын Ерөнхий сайдын дэргэдэх орон тооны бус зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга	хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт

		оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөр	өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн боловсролын үйлчилгээ үзүүлсэн байдал											
1.2	A13. Хүн амын соёл, урлагийн боловсролыг дэмжсэн нэвтрүүлэг,	Контентийг дэмжих хөтөлбөр Монгол уран бүтээлийг үндэсний хөтөлбөр	монголын түүх, үндэсний соёл, зан заншил, ахуйг харуулсан радио, телевизийн нэвтрүүлэг, хөтөлбөр цахим орчин дахь агуулга, мэдээ мэдээллийг нэмэгдүүлэх байдал	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	Монгол уран бүтээлийг радио, телевиз, киноны зах зээл, цахим орчинд нэмэгдүүлэх замаар хойч үедээ уламжлалт соёл, түүх, зан заншлыг өвлүүлэн уламжлуулах, өв соёлоо хадгалж, хамгаалах, үндэсний соёлоор бахархах үзлээр хүмүүжүүлэх, дэлхийн зах зээлд үндэсний соёлыг сурталчлах, монгол уран бүтээлчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхээр зорилгоо тодорхойлсон	Хууль	Олон нийтийн радио, телевизийн тухай	8.2.3	10.1	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хэрэгжүүлэх үүргийг соёлын асуудал эрхэлсэн сайдын томилсон комисс, ОНРТ	улсын хэмжээнд стратеги, удирдлага төлөвлөлтөөр хангах, зохицуулах,
1.4	X1. Соёлын аялал	"Соёлын үйлдвэрлэл"	Аялал жуулчлалын салбар дахь соёлын аялал жуулчлалын өсөлт.	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох	үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын	Бодлогын	Төрөөс соёлын			соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн	хяналт, шинжилгээ-

		үндэсний хөтөлбөр					үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулахад оршино.				холбогдох байгууллагууд		
4.5	Х2. Соёл, урлагийн байгууллагууд	"Соёл урлагийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх" хөтөлбөр	Соёлын ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	Хууль	Соёлын тухай хууль	13.1.10	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Соёлын байгууллага	Соёлын сайд Соёл урлагийн газар хариуцна	
4.6	Х3. Уран бүтээлчид	бүтээл туурвилын үр	"Соёлын үйлдвэрлэл" үндэсний	4.5.2. соёл, урлагийн шилдэг бүтээлийг зохиогчийн эрхээр баталгаажуулан дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн үйлдвэрлэн	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	хууль	Соёлын тухай хууль, оюуны өмчийн тухай	32.1-32.13	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Соёлын байгууллага	Соёлын сайд Соёл урлагийн газар, Оюуны

		хөтөлбөр	танилцуулах, борлуулах зорилготой уран бүтээлч, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих;					нийтэд сурталчлан таниулахад оршино.					
17	Х4. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын зах зээлд	"Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөр	4.6.4. монгол уран бүтээлчдийн шилдэг бүтээлийг шалгаруулж, олон улсын зах зээлд сурталчлах, худалдах, олон улсын нэр хүндтэй байгууллагад ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах;	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулахад оршино.	Хууль	Соёлын тухай хууль	27.1.1-27.1.9, 28.1.1-28.1.3, 29.1	Төрийн холбогдох байгууллагууд болон тухайн улсад сугаа элчин сайд	Гадаад харилцаа, санхүү төсөв, соёл, боловсролын асуудал
18	Х5. Соёлын биет бус өв устах эрсдэлтэй	Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсн	ЮНЕСКО-д бүртгүүлсэн өв	14	16	Байхгүй	Тооцох боломжгүй	Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн соёлын биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах,	Хууль	Соёлын тухай хууль	13.1.6	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах,

24	X8. Урлагийн	"Зөв Монгол хүүхэд"	Зорилт 7.2.	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох	Монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах	Хууль	Соёлын тухай хууль	16.1.2	Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын	
25	X7. Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвүүдийн конвенцын	Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр	үзлэг, судалгаа	-	2	Байхгүй	Тооцох боломжгүй	Монгол Улсын нутаг дэвсгэрт амьдарч байгаа монгол угсаатны олон бүлгийн соёлын биет бус өвийг олж илрүүлэх, судлах, бүртгэн баримтжуулах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх	Бодлогын баримт бичиг	Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	4.3.12	соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн холбогдох байгууллагууд	хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, цаашдын хөгжлийн зорилтыг
40	X6. Соёлын өвд суурилсан	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлэх	Бодлогын баримт	Төрөөс соёлын талаар баримтлах	4.4.8	соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн холбогдох байгууллагууд	хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж,

		хөтөлбөр					чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж төлөвших гэр бүл, боловсрол, нийгмийн орчныг бүрдүүлэх				асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, соёлын байгууллагын удирдлага	
᠑᠑	Х9. Урлагийн хөгжилд урлаг судлал, шүүмжийн ач	"Сонгодог урлаг-III" хөтөлбөр	3.2. Урлаг судлал шүүмж судлалыг шинэ түвшинд гаргах	᠐	2	Байхгүй	Тооцох боломжгүй	Хууль	Кино урлагийг дэмжих тухай	1᠐.2.8	Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Зөвлөл болон мэргэжлийн хяналтын байгууллага	хяналт шинжилгээ хийнэ
᠑᠑	Х10. Соёл, урлагийн салбарт цахим	"Цахим засаглал" үндэсний хөтөлбөр	Цахим засаглалын хатуу болон зөөлөн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлэх	᠐.597	᠐.᠖5	Байхгүй	Тооцох боломжгүй	Хууль	Соёлын тухай хууль	᠑.1.9	Засгийн газар, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн	

		Монгол чууд хөтөлб өр												
13	X13. Олон улсад Монголын имиж бүрдээгүй	Монгол Улсыг гадаад ад суртал члах хөтөлб өр	9.1.3 Сурталчилсан брэндийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэгч, аж ахуй нэгжийн тоо	Байхгүй	Байхгүй	Байхгүй	Тооцох боломжгүй	Монгол Улсын гадаад сурталчилгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, гадаад сурталчилгааны нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгох, гадаад сурталчилгаагаар дамжуулан гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Хууль	Гадаад сурталчилгааны тухай	30.1	Засгийн газар, боловсрол, соёл, спорт, аялал жуулчлал болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн нарийн бичгийн дарга болон урлаг, спорт, кино, хэвлэл мэдээлэл, бизнесийн байгууллага, мэргэжлийн холбоо, эрдэмтэн судлаачид	зохион байгуулах, хэрэгжүүлэх, зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.	

Хүснэгт 2.6. Нөхцөл байдлын нэгтгэсэн шинжилгээ хийх ажлын хүснэгт

Алхам 2. Оролцогч шинжилгээ	Алхам 3. Асуудал/хэрэгцээний шинжилгээ	Алхам 4. Асуудлын шалтгаан тодорхойлох	Алхам 5. Асуудлын үр дагаврыг тодорхойлох	Алхам 6. Бодлогын шинжилгээ	Алхам 7. Шаардлагатай нөөцийн урьдчилсан тооцоо хийх
Соёл, урлагийн байгууллага	А1. Соёлын салбарын хөгжлийн өнөөгийн байдлыг үнэлэхэд шаардлагатай статистик мэдээлэл хангалтгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээ гаргадаг, хувийн хэвшлийн цөөн тооны байгууллага мэдээлэл ирүүлдэг	Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй	Хийгдсэн	100,000,000
Төрийн захиргааны байгууллага	А2. Соёлын бодлого боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээлэл дутмаг	Соёлын бодлогын судалгааны байгууллага байхгүй, соёлын бодлогын судлалын мэргэшсэн судлаач хомс, санхүүжилт хангалтгүй	Нотолгоонд суурилсан бодлого боловсруулах боломжгүй	Хийгдсэн	200,000,000
Соёл, урлагийн байгууллага	А3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавх сул	Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөл хуучирсан, менежмент нь хоцрогдсон, хүний нөөцийн чадавх сул	Хүн ам соёл, урлагийн байгууллагаар	Хийгдсэн	500,000,000

			үйлчлүүлэхээс татгалзах		
Гэр бүл	A4. Соёл, урлагийн байгууллагад хүн ам гэр бүлээрээ чөлөөт цаг өнгөрүүлэх боломжгүй	Соёл, урлагийн байгууллагын орчин хангалтгүй, үйлчилгээний чанар хангалтгүй, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээг хангадаггүй	Хүн ам соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэхээс татгалзах	Хийгдсэн	1,000,000,000
Орон нутгийн соёлын байгууллага	A5. Соёлын биет өв устах эрсдэлтэй байна.	Соёлын биет бус өвийн эрсдэлийн үнэлгээ хийдэггүй, санхүүжилт хангалтгүй, хээрийн болон археологийн судалгаа бараг хийдэггүй, нийгэмд өвийн үнэ цэнийг ойлгуулахад чиглэсэн зорилтот үйл ажиллагаа тогтмол бус, уул уурхайн компаниудад ойлголт байхгүй	Соёлын биет өвийн хадгалалт, хамгаалалтыг доройтуулах, тонох, хулгайлах, хууль бусаар хил нэвтрүүлэх, худалдаалах устгах, сүйтгэх зэрэг бүх төрлийн эрсдэлд орж байна.	Хийгдсэн	800,000,000
Урлагийн байгууллага	A6: Өндөр түвшний мэргэжлийн уран бүтээлчид дутагдалтай	Соёл, урлагийн хөдөлмөрийн эдийн засгийн эрэлт, нийлүүлэлтийн бодлого байхгүй, шаардлагатай урлагийн мэргэжлээр суралцахыг	Мэргэжлийн уран бүтээл туурвихад хүндрэлтэй болно.	Хийгдсэн	200,000,000

		дэмжсэн тэтгэлэг байхгүй, урлагийн байгууллагын урын сангийн бодлого ба хүний нөөцийн төлөвлөлт уялдаагүй			
Мэргэжлийн холбоод	A7. Салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын гүйцэтгэх үүрэг хангалтгүй	Мэргэжлийн холбоодын менежментийн чадавх сул, салбарын хөгжлийн бодлого боловсруулахад манлайлан оролцох, нөхцөл байдлыг мэргэшлийн түвшинд үнэлж, Төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах талаар санаачилга байхгүй, холбоодын удирдлагууд хувийн эрх ашиг, сонирхлоо чухалчилдаг	Салбарын хөгжлийн бодлогын тогтвортой, шинжлэх ухааны үндэслэлтэй байх боломжгүй болно.	Хийгдсэн	100,000,000
Төрийн захиргааны байгууллага	A8. Монгол Улсын гадаад харилцааны бодлогод соёл, урлагийн салбарын оролцоо сул	Гадаад хамтын ажиллагааны сүлжээнд элсэж ороогүй. Гадаад хэлний өндөр чадвартай ажиллагчид цөөн, төсөв хөрөнгө байхгүй.	Монгол Улсын дүр төрхийг олон улсад соёл, урлагийн илэрхийлэх боломж алдагдана.	Хийгдсэн	300,000,000

Соёл, урлагийн байгууллага	А9. Соёл, урлагийн байгууллагууд зохиогчийн эрхийн менежмент хэрэгжүүлэх чадамжгүй	Зохиогчийн эрхийн тухай ойлголт тааруу, төсөв байхгүй, зохиогчийн эрхтэй холбоотой статистик мэдээлэл хомс, хэрхэн хамгаалах арга зам тодорхойгүй. Мэдээллийн эх сургалт хомс.	Уран бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй болох, уран бүтээлчдийн хувийн өмч үнэгүйднэ.	Хийгдсэн	400,000,000
Соёлын ажилтан	А10. Соёлын ажилтнууд ур чадвар нийгмийн хөгжлийн шаардлагыг хангаж чадахгүй	Төрөөс соёлын ажилтны мэргэжил дээшлүүлэх талаар баримтлах бодлого тодорхойгүй, ажлын орчин нөхцөл тааруу, цалин урамшуулал бага, мэргэжил дээшлүүлэхэд орон нутаг, байгууллагаас эдийн засгийн дэмжлэг байхгүй,	Соёлын ажилтны нийгмийн баталгаа алдагдана.	Хийгдсэн	35,000,000
Хүүхэд залуучууд	А11. Хүүхэд, залуучуудад түүх, өв соёлоо дээдлэх, хүндэтгэх хандлага төлөвшөөгүй	Хүүхэд, залуучуудад соёл, урлагийн боловсрол олгоход соёл - боловсролын хамтын ажиллагаа сул, соёлын боловсрол олгох хүрээнд хамтын ажиллагаа байхгүй, Соёлын боловсрол олгох үндэсний хэмжээний хөтөлбөр байхгүй. Сургалтын хөтөлбөрт нэгдмэл агуулга байхгүй	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Хийгдсэн	600,000,000

Тусгай хэрэгцээт иргэд	А12. Соёлын үйлчилгээ авах, соёлын боловсрол хүртэх боломж хязгаарлагдмал	Соёл, боловсролын үйлчилгээний байгууллагад тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан орчин нөхцөл, техник тоног төхөөрөмж, бүлгийн онцлогт тохирсон хөтөлбөр, дэмжлэг байхгүй, энэ талын ойлголт төлөвшөөгүй	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох, өөрийгөө хөгжүүлэх боломж алдагдана.	Хийгдсэн	1,000,000,000
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	А13. Хүн амын соёл, урлагийн боловсролыг дэмжсэн нэвтрүүлэг, контент дутагдалтай	Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагад тогтоосон хөтөлбөр, эфирт эзлэх соёлын боловсролын агуулгатай контентыг нэвтрүүлэх цаг бага, нийтэд хүргэх санхүүгийн дэмжлэг байхгүй	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Хийгдсэн	700,000,000
Аялал жуулчлалын байгууллага	Х1. Соёлын аялал жуулчлалд соёлын байгууллагын оролцоо хангалтгүй	Орон нутгийн соёлын байгууллагад олон талт үйлчилгээ байхгүй, бусад салбартай хамтран ажиллах тал дээр санаачилгагүй, зөвхөн улсын болон орон төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг	Соёл, урлагийн байгууллагын санхүүгийн чадавх болон өрсөлдөх чадвар буурна	Хийгдсэн	500,000,000

Соёл, урлагийн байгууллага	Х2. Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн хүний нөөцийн дутагдалтай	Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн эрэлт-нийлүүлэлтийн зохицуулалт байхгүй, соёлын ажилтны цалин бага, нийгмийн баталгаа хангалтгүй,	Соёл, урлагийн байгууллагууд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийн хомсдол орно.	Хийгдсэн	700,000,000
Чөлөөт уран бүтээлчид	Х3. Уран бүтээлчид бүтээл туурвилын үр шимийг хүртэж чадахгүй	Уран бүтээлчдэд зохиогчийн эрхийн талаар ойлголт хангалтгүй, урлагийн менежмент хийх туршлага сул, мэргэшсэн менежер, продюсер байхгүй	Уран бүтээлчид уран бүтээлээс тогтмол орлого олох боломжгүй.	Хийгдсэн	300,000,000
Кретив компани	Х4. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар сул	Кретив компани хөрөнгө оруулалт татах боломжгүй, төрөөс дэмжлэг байхгүй, олон улсын зах зээлд өрсөлдөх үндэсний брэндийн нэгдсэн бодлого байхгүй	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр хангалтгүй байна.	Хийгдсэн	2.000,000,000

Өвлөн уламжлагчид	Х5. Соёлын биет бус өв устах эрсдэлтэй	Өвлөн уламжлагчдыг дэмжлэг, урамшуулал хангалтгүй, соёлын биет бус өвийг судлах, баримтжуулах, сан бүрдүүлэх ажил удаашралтай, өвлөн уламжлагчид өөрсдийн ур чадвараар хөдөлмөр эрхлэх, жижиг бизнес эрхлэх болон үр шимийг нь хүртэх ойлголт байхгүй,	Соёлын биет бус уусах, уламжлалт мэдлэг мартагдах, устах эрсдэлд орж байна.уламжлалт мэдлэг, туршлага мартагдаж, өвийн оршин тогтнох байдалд шууд эрсдэл үүсэж байна.соёлын биет бус өв уусах, мартагдах, соёлын орон зай эзгүйрэх, үнэ цэн, ач холбогдол алдагдах эрсдэл үүсэж байна,	Хийгдсэн	500,000,000
Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид	Х6. Соёлын өвд суурилсан брэндийн өрсөлдөх чадвар сул	соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн чадавх сул, соёлын өвд суурилсан брэнд хөгжүүлэх туршлага бага,	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн гадаад худалдаа хангалтгүй.	Хийгдсэн	3,000,000,000

		үндэсний брэндийн нэгдсэн бодлого байхгүй,			
Төрийн захиргааны байгууллага	X7. Монгол улсаас Дэлхийн өвд бүртгэгдсэн өвүүдийн конвенцын хэрэгжилт сул	ЮНЕСКО-ийн Дэлхийн өв болон Соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн өвийн хадгалалт, хамгаалалтыг тус Конвенциудын үзэл баримтлалын дагуу хангахад хүндрэл учирч байна.ЮНЕСКО-ийн Дэлхийн өв болон Соёлын биет бус өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оролцогч талуудын оролцоо дутмаг, хангалтгүй байна.	Конвенцын үзэл баримтлалтай зөрчилдөх эрсдэлтэй.	Хийгдсэн	700,000,000
Менежер, продюссер	X8. Урлагийн салбарт талант менежмент хөгжөөгүй	Талант менежментийн талаар ойлголт хангалтгүй, өнгөц байдлаар ханддаг, урлагийн байгууллагуудыг менежментийн суурь ойлголтгүй хүмүүс удирддаг, бизнесийн зарчмаар ажиллах арга барил эзэмшээгүй	Уран бүтээлчид тогтвортой орлого олж чадахгүй, амьдралын чанар сайжрахгүй.	Хийгдсэн	2,000,000,000
Мэргэжлийн холбоод	X9. Урлагийн хөгжилд урлаг судлал, шүүмжийн ач холбогдлыг ойлгохгүй	Урлаг судлалыг төрөөс дэмжих бодлого, уран бүтээлчид уран бүтээлд нь мэргэжлийн шүүмж	Хүн амын урлагт хандах хандлага	Хийгдсэн	1,000,000,000

		өгөхөөс айдаг, тайз, дэлгэц дээр тоглогдох бүтээлд мэргэжлийн талаас шүүмж өгөх соёл төлөвшөөгүй	буурч, нийгэмд үнэ цэнгүй болно.		
Студи, продакшн	X10. Соёл, урлагийн салбарт цахим шилжилт удаашралтай	Санхүүжилт хүрэлцээгүй, нарийн мэргэжилтэн бэлтгэгдээгүй. Орчин нөхцөл тааруу.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үндэсний эдийн засагт оруулах хувь нэмэр хангалтгүй байна.	Хийгдсэн	2,000,000,000
Гэр бүл	X11. Нийгэмд үндэсний нэгдмэл үнэт зүйлийн талаарх ойлголт муу	Монголчууд уламжлалт ёс заншил, түүхийн талаарх соёлын боловсрол олгох тогтолцоо тодорхой биш, шинжлэх ухааны үндэслэл тодорхойлох талаар санаачилга байхгүй, бусдын хийсэн зүйлийг хүлээн зөвшөөрдөггүй	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Хийгдсэн	1,000,000,000
Гадаадад амьдарч байгаа монголчууд	X12: Монгол хэл, соёлын дархлаа суларсан	Төрийн зүгээс гадаадад амьдарч байгаа монголчуудад Монгол хэл, түүх өв соёлоосоо суралцах боломж олгох санаачилга сул, мэргэшсэн багш бэлтгэгдээгүй, шинжлэх ухааны үндэстэй сургалтын нэгдсэн	Үндэсний түүхий соёлын өвд хүндэтгэлтэй хандах, дээдлэх байдал алдагдана.	Хийгдсэн	900,000,000

		хөтөлбөр байхгүй, төрөөс ямар нэг дэмжлэг байхгүй			
Төрийн захиргааны байгууллага	X13. Олон улсад Монголын имиж бүрдээгүй	Монголын имиж бий болгох, санаачилга, зохион байгуулалт, мэргэжлийн баг бүрдүүлэлт, санхүүгийн дэмжлэг байхгүй	Монгол Улсын дүр төрхийг олон улсад соёл, урлагийн илэрхийлэх боломж алдагдана.	Хийгдсэн	800,000,000

ГУРАВ. СОЁЛЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Төрөөс баримталж буй соёлын бодлого тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдаж буй байдлыг (3.22), одоо мөрдөгдөж буй хууль, эрх зүй нийгэм, эдийн засгийн чиг хандлагатай уялдаж буй байдлыг (3.06), аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ийн удирдлагаас гаргаж буй тушаал шийдвэр төрийн соёлын бодлоготой уялдаж буй байдлын ерөнхий үнэлгээ (3.04) буюу дундаж байгаа хэдий ч 8 аймгийн мэргэжилтэн нийцлийн түвшин сул буюу уялдаа муутай хэмээн үнэлсэн бол Завхан, Орхон, Төв аймгийн удирдах ажилтнууд (3.50-3.71) буюу нийцлийн түвшин сайн гэж үнэлсэн байна. Судалгаанаас үзэхэд эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, нийгэм, эдийн засгийн байдалтай уялдуулах, боловсруулалтын түвшинд анхаарах, сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.



Зураг 3.1. Соёлын бодлогын хэрэгжилтийн байдлын хамаарал

Соёлын бодлогын хэрэгжилтийн байдлыг 8 үзүүлэлтээр үнэлэхэд ерөнхий үр дүн 3.21 буюу дундаж түвшинд байна. Үндэсний хөгжилд соёл, урлагийн гүйцэтгэх үүргийг (3.71) буюу дундаж гэж үнэлсэн нь нийт үзүүлэлтээс хамгийн өндөр, аймаг, нийслэл, сум, дүүрэгт төрийн соёлын бодлогын хэрэгжилтийн байдал (3.37), аймгийн БСУГ-аас соёлын бодлого, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах боломж болон дотоодын бусад байгууллагатай хамтран ажилладаг байдлыг (3.32), аймаг, нийслэлийн удирдлагаас дэмжлэг үзүүлдэг байдлыг (3.29), төрийн

захиргааны байгууллагаас соёлын бодлогын талаар мэдээлэл авах боломжийг (3,14) буюу дундаж, олон улсын түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байдлыг (3.01) буюу дунджаас доогуур, соёлын үйл ажиллагаанд хүн амын оролцооны байдлыг (2.56) буюу муу гэж хамгийн бага түвшинд үнэлжээ.

Нэгтгэн дүгнэвэл, аймаг, нийслэл буюу харьяалах нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллагуудын туслалцаа дэмжлэг сул, мэдээлэл цаг хугацаандаа хүрдэггүй, аймаг, сумдад олон улсын соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад зах зээлд уран бүтээл үйлчилгээгээ таниулах, сурталчлах, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын соёлын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай харагдаж байна.



Зураг 3.2. Соёлын бодлогын хэрэгжилтийг сайжруулахад анхаарах асуудал, хувиар

Соёлын бодлогын хэрэгжилтийг сайжруулахад анхаарах асуудал 20.3% нь хэрэгжилтийг хангах санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгож нэмэгдүүлэх, 18.3% нь салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэж хариулсан нь соёлын салбар санхүүжилт бага, мөн нийгмийн баталгаа доогуур байдаг нь харагдаж байна. Мөн 14.2% нь бодлогоо өөрчлөн сайжруулах шаардлагатай, 12.8% нь төрийн болон орон нутгийн өмчийн соёл, урлагийн байгууллагыг дэмжиж бэхжүүлэх нь нэн чухал байна.

Монгол Улсын Засгийн Газраас үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрүүдэд туссан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу

гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа гэж үзэн гүйцэтгэлийн байдлыг харгалзан 75.6 (60-80 хүртэл хувь) үнэлсэн байна.


Хүснэгт 3.1. Үндэсний хэмжээнд хэрэгжсэн хөтөлбөрийн Засгийн газар болон хөндлөнгийн үнэлгээний харьцуулалт

№	Хэрэгжсэн хөтөлбөрүүд	ЗГ-ын үнэлгээ	Хэрэгжилтийн үр дүн	Хөндлөнгийн үнэлгээ
1	Монгол бичиг (2008-2015)	95.7	Их, дээд сургууль, коллежид элсэгчид монгол хэл, бичгийн шалгалтыг өгдөг боллоо.	3.34
2	Авьяас хөтөлбөр (2013-2016)	99	“Авьяас” хөтөлбөр хэрэгжсэнээр 2014-2015 оны хичээлийн жилд 121 төрлийн дугуйлан, секцэд давхардсан тоогоор нийт суралцагчийн 110 хувь нь хамрагдлаа.	3.74
3	Ном хөтөлбөр (2013-2016)	99	“Авьяас”, “Ном”, “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын чанарын шинэчлэл” дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна. Нийслэлийн дунд, ахлах анги бүр ангийн номын сантай боллоо	3.72
4	Сонгодог урлаг II хөтөлбөр (2011-2016)	60	Сонгодог урлагийн байгууллагуудын хөгжмийн зэмсэг, гэрэл, дууны тоног төхөөрөмжүүд шинэчлэгдлээ	2.90
5	Монгол хөөмий хөтөлбөр (2005-2014)	60	Хөөмийчдийн тоо гурав дахин өслөө	3.05
6	Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах (2008-2015)	65	Түүх, соёлын дурсгалууд сэргээн засварлагдлаа	3.41
7	Бий биелгээ (2009-2014)	90	Шинэ үеийнхэн уламжлалт бий биелгээг өвлөн авлаа	3.33
8	Монгол тууль (2012-2014)	50	Монгол туулийг баримтжуулж, олон нийтэд сурталчиллаа	2.94
9	Морин хуур, уртын дуу хөтөлбөр (2005-2014)	98	9242 морин хуурч, 2766 уртын дууч шинээр бэлтгэгдэж байна	3.66
10	Монгол цуур хөтөлбөр (2014-2016)	10	82 хүн цуурын урлагт суралцаж байна	2.85

11	Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах хөтөлбөр (2015-2016)	0	Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр (2015-2022)	3.46
12	Монгол судлал хөтөлбөр (2012-2016)	90	Хилийн чандад монгол судлалын 18 төв ажиллаж байна	2.94
	Үнэлгээний дундаж	74.2	Үнэлгээний дундаж	3.28

Эдгээр хөтөлбөрүүдээс морин хуур, уртын дуу хөтөлбөр 98 хувь, авьяас хөтөлбөр 99 хувь, ном хөтөлбөр 99 хувьтай зорилгоо биелүүлсэн гэж хангалттай сайн гэж үнэлсэн бол, Монгол тууль хөтөлбөрийн хэрэгжилтийг 50 хувьтай, Монгол цуур хөтөлбөрийг 10%-тай буюу хангалтгүй хэрэгжсэн гэж үнэлжээ. Аливаа үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх зэрэг бүхий л үе шатанд олон нийтийн санаа бодол, мэргэжлийн байгууллагын судалгаа дүгнэлтэд үндэслэхийн сацуу нэгэнт баталсан хөтөлбөрийн хэрэгжилтийг явцад нь болон хэрэгжиж дууссаны дараа албан ёсны үнэлгээ хийж дүгнэлт гарган цаашдынхаа бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж байх шаардлагатай байдаг.


Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн үндэсний хөтөлбөрүүд аймаг, нийслэлийн түвшинд хэр зэрэг хэрэгжсэнийг 12 хөтөлбөрийн хүрээнд авч үзэхэд ерөнхий үнэлгээ 3.28 буюу дундаж түвшинд байна.



Зураг 3.3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээ

Улсын хэмжээнд Авьяас хөтөлбөр (3.74), Ном хөтөлбөр (3.72), Морин хуур, уртын дуу хөтөлбөр (3.66) буюу хамгийн өндөр хэрэгжилтийн үнэлгээтэй гарсан нь манай орны хувьд хүн амын 63.75%¹-ийг эзэлж буй хүүхэд залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжих боломжтой бөгөөд үр дүн өндөр байгаа болон “Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай”² ерөнхийлөгчийн зарлиг, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн гэж үзэж болохоор байна.

Монгол улсын Засгийн газраас соёл, урлагийн салбарт шинээр болон цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй 7 хөтөлбөр байна. Эдгээр үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжих боломжийг үнэлэх зорилгоор судалгаа авч нэгтгэн үзэхэд улсын дундаж 3.78%-тай буюу дундаж түвшинд байна.



Зураг 3.4. Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжих боломжийн хөндлөнгийн үнэлгээ

Судалгааны үр дүнгээс харахад үндэсний хөтөлбөрүүдээс “Соёлын биет бус өвийг хамгаалах” хөтөлбөрийг (4.32), Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр (4.03), Соёлын үйлдвэрлэл хөтөлбөрийг (4.01) буюу хэрэгжих бүрэн боломжтой гэж үнэлсэн бол бусад хөтөлбөрүүдийг (3.28-3.76) буюу дундаж гэж үнэлсэн байна.

¹ 1212.тн 2018 оны статистик

² “Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай” Монгол улсын ерөнхийлөгчийн зарлиг 2002.02.11, №17

Соёлын бодлогын хэрэгжилтийн өнөөгийн байдал дундаас доогуур буюу хангалтгүй хэмжээнд эрх зүйн орчин, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт сайн биш гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Судалгаанд хамрагдагчид соёл, урлагийн салбарт эрх зүйн орчин бүрдсэн байдлыг 2.44 буюу хангалтгүй түвшинд байна гэж үзсэн. Нийт оролцогчдын 30.2% нь соёл, урлагийн салбарт эрх зүйн орчин хангалттай бүрэлдэж чадаагүй, 56,3% нь учир дутагдалтай гэж үнэлсэн байна. Харин соёлын бодлого тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдаж буй байдлыг (3.22), одоо мөрдөгдөж буй хууль, эрх зүй нийгэм, эдийн засгийн чиг хандлагатай уялдаж буй байдлыг (3.06) аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ийн удирдлагаас гаргаж буй тушаал, шийдвэр төрийн соёлын бодлоготой уялдаж буй байдлыг (3.04) буюу нийцлийн түвшин дундаж боловсруулалт хэрэгжилтийн түвшинд анхаарах шаардлагатай гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, соёл, урлагийн салбарыг хөгжүүлэх хууль, эрх зүйн үндэс бүрэлдсэн боловч өөр хоорондын уялдаа холбоо тааруу, бодлогын хэрэгжилтэд анхаарах зүйл харагдаж байна. Иймд соёл, урлагийн салбарын төрийн бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх шинэтгэлийг хийхдээ Монгол хөрсөндөө буусан, нүүдлийн соёл иргэншлийн онцлогийг тусгасан, монгол хүний оюуны эрэлт хэрэгцээнд нийцсэн байх чиглэлийг баримтлан шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгаа, тооцоонд үндэслэх шаардлагатай байна.

Манай улсын хөгжил, нийгмийн дэвшилд соёл, урлагийн салбар үүргээ тодорхой хэмжээнд биелүүлж байгааг судалгааны дүн харуулав. Судалгаанд хамрагдагчид нийгмийн хөгжилд соёл, урлагийн гүйцэтгэх үүргийг (3.71) буюу хангалттай гэж үнэлсэн бол олон улсын түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байдлыг (3.01), соёлын үйл ажиллагаанд хүн амын оролцооны байдлыг (2.56) буюу дунджаас доогуур түвшинд үнэлжээ. Иймд аймаг, нийслэл буюу харьяалах нутаг дэвсгэрийн төрийн захиргааны байгууллагуудын туслалцаа дэмжлэг сул, мэдээлэл цаг хугацаандаа хүрдэггүй байдлыг арилгах, аймаг, сумдад олон улсын соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад зах зээлд уран бүтээл үйлчилгээгээ таниулах, сурталчлах, соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амын соёлын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Салбарт хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд явцын болон гүйцэтгэлийн хяналт-үнэлгээг орчин үеийн нийтлэг арга зүйн дагуу тухай бүр хийдэггүйгээс хэрэгжсэн гэх төсөл, хөтөлбөрүүдийн үр дүн, өгөөж нь төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна.

Манай орны хувьд үндэсний хөтөлбөрүүд түүний хэрэгжилтийг үнэлэх талын судалгаа хомс, судалгааны санхүүжилт бага байгаа нь анхаарал хандуулах асуудал мөн. Иймд бид соёл, урлагийн салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлыг үнэлэх зорилгоор 12 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд судалгаа хийхэд ерөнхий үнэлгээ (3.28) буюу дундаж түвшинд байна. Улсын хэмжээнд Авьяас хөтөлбөр (3.74), Ном хөтөлбөр (3.72), Морин хуур, уртын дуу хөтөлбөр (3.66) буюу хамгийн өндөр хэрэгжилтийн үнэлгээтэй гарсан. Харин “Сонгодог урлаг II”, “Монгол цуур”, “Монгол тууль”, “Монгол судлал” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг (2.85-2.94) хамгийн бага үнэлсэн нь орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудын хувьд, ялангуяа сумдад дээрх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон орчин нөхцөл, мэргэжлийн хүний нөөцийн дутагдалтай, зарим хөтөлбөрүүдийн хувьд газар зүйн байрлал, угсаатны онцлог, соёлын өвийг өвлөн тээгчид цөөн, өвлөн уламжлуулах зааж сургах нөхцөл боломж тааруу, санхүүжилтийн эрх мэдлийг бүрэн олгоогүй зэрэг олон асуудалтай холбоотой байна.

Соёл урлагийн салбарт одоогоор хэрэгжиж буй үндэсний 7 хөтөлбөрийн хэрэгжилтийн өнөөгийн байдлын судалгааг нэгтгэн үзэхэд ерөнхий үнэлгээ 3.78 буюу хангалттай сайн хэрэгжиж байгаа нь судалгаанаас харагдана. “Соёлын биет бус өвийг хамгаалах” хөтөлбөр (4.32), Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр (4.03), Соёлын үйлдвэрлэл хөтөлбөр (4.01) буюу хэрэгжих бүрэн боломжтой, хангалттай хэрэгжиж байгаа гэж үнэлсэн бол бусад хөтөлбөрүүдийг (3.28-3.76) буюу дундаж гэж үнэлсэн байна. Харин “Сонгодог урлаг III” хөтөлбөрийг (3.28) буюу хамгийн бага үнэлснээс үзэхэд орон нутгийн соёл, урлагийн байгууллагуудын хувьд, ялангуяа газар зүйн байршлын хувьд алслагдсан аймаг, сумдад “Сонгодог урлаг-III” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зүйл байгаа нь харагдаж байна.

Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын 9 эрхэм зорилгын 1-д:

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл-”Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно”.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл

Өнөөдөр манай улсад Үндэсний үнэт зүйл гэдгийг ард иргэд байтугай судлаач эрдэмтэд бүрэн гүйцэд томъёолж амжаагүй, үнэт зүйлсийн судалгаа одоогоор

дөнгөж эхлэлтийн байдалтай байна. Соёл урлагийн их сургууль, Удирдлагын академи, Үндэсний брэндийн зөвлөл тус тусын үнэт зүйлийн судалгааг (2018-2019) хийгээд удаагүй байна. Судалгааг олон нийтэд түгээх, хэлэлцүүлэх, сурталчлах ажлыг энэ цаг үед зохион байгуулж үндэсний үнэт зүйлсийг нэгдмэл байлгах шаардлага тулгарсаар байна. Дэлхийн олон улсуудад өөрсдийгөө “Сор үндэстэн” (Nation-Brand) болгох ажил ид өрнөж байна. Гэтэл манайханд “Сор үндэстэн” (Nation-Brand) гэх ойлголтыг дэлгүүрийн бараа бүтээгдэхүүн гэдгээс ялган салгаж ойлгохгүй байна. Түүх, соёлын талаарх нэгдмэл үзэл бодол сарниж, олон янзын үзэл дэлгэрэх хандлага байна. Түүх соёлын мэргэжлийн биш хүмүүс өөр өөрсдийн үзэмж дур зоргоор хандаж, төрийн бус байгууллага, нийгэмлэгүүд байгуулж, бодит баримт, түүхэн үнэнээс зөрөөтэй дүгнэлт гарган, түүгээр жирийн ард олныг төөрөгдүүлэх явдал гарсаар байна. Үүнээс үүдэн үндэсний нэгдмэл байдал, соёлын дархлаа, үндэсний аюулгүй байдлын асуудал давхар хөндөгдөж байна. Үндэсний тулгуур үнэт зүйлсийг эгнэгт өөрсдийн халдашгүй брэнд болгох, үндэсний ижилсэл, ондоошлоо бүтээх үйл хэрэг хоёр хэлбэрээр өрнөж байна. 1. Өөрийн түүх соёлын тухай эх сурвалж дахь нэг мөр, нэг үгийг ашиглан дөвийлгөж, том түүх бүтээх, заримдаа санаанаасаа зохиох 2. Өөрийн түүх, соёлын баялаг эх сурвалжаас бодит түүх, байсан үнэт зүйлээ нэхэн сэргээх, түүхэн үнэнийг тогтоох ийм хоёр зүйлийн оролдлого гарч байна. Сүүлийн жишээ нь бидэнтэй шууд холбоотой. Манай орны хувьд өөрийн гэсэн давуу болон сул тал байгааг товч авч үзвэл:

Давуу тал: Монголын түүх, соёлын сурвалжууд дэлхийн олон хэлээр (араб, перс, хятад, латин, төвөд, орос) эмх цэгцтэй байж байна. Энэ талын асар их уламжлалтай тул зарим улс орон шиг санаанаасаа зохиох шаардлагагүй, түүхийн эх сурвалжийг судалж, нэхэн сэргээх ажлыг эрчимжүүлэх аваас өргөн боломж байсаар байна. МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО 2050 50 51 НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ Манай оронд түүх, хэл, соёл, археологи, палеонтологийн судалгаагаар шинэ шинэ ололт нээлтүүд гарч, үндэсний үнэт зүйлийн хүрээ, агуулга, төрөл зүйл улам өргөссөөр байна. Монгол улс бол үндэстэн угсаатны хоорондын дайсагнал, хурц зөрчил, тэмцэлгүй нэг хэл, соёлтой нэг үндэстэн гэдгээрээ онцлог талтай билээ. Нөгөөтээгүүр дэлхийн бусад улс орны зүгээс Монголын түүх, соёлыг сонирхох сонирхол улам нэмэгдэж, өөрийн давтагдашгүй мөн чанараараа гайхагдах болж байна.

Сул тал: Үндэсний үнэт зүйлийн талаарх орчин үеийн ойлголтын түвшин доогуур, түүх, соёл, уламжлалын тухай мэдлэг өнгөцхөн, боловсролын тогтолцоонд эзлэх байр суурь сул байгаагаас, нэн ялангуяа хүүхэд залуусын дунд харийн нөлөө түрж, гадаадын соёл, шашин суртахуунд автах байдал их болж байна. Үүний улмаас түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл, булш, хиргисүүрийг ухаж төнхөх, зарж үрэх, үнэт олдворыг гадагш гаргадаг бүлэглэлүүд идэвхжиж, хуулийн хариуцлага хүлээдэггүй байдал даамжирчээ. Энэ бүгд үндэсний ижилсэл, соёлын дархлаа, үндэсний аюулгүй байдалд ноцтой эрсдэл учруулсаар байна. Монголчууд эртнээс эдүгээг хүртэл эх орон, газар нутаг, тусгаар тогтнол, уламжлалт амьдрах ухаан, үндэсний өв соёл, эв нэгдэл, эрдэм боловсрол, ахмад үе, ахас ихсээ хүндэлж, ажил хөдөлмөр, байгаль дэлхийгээ дээдэлж ирснээс гадна эх хэл, гэр бүл, үр хүүхэд, хүн хүнээ дээдлэх ёсыг өндөрт өргөсөөр түүхэн он цагийг туулж өнөөг хүрсэн билээ. Сүүлийн үеийн судалгаагаар монгол үндэсний хэл бичиг, өв соёл, нүүдлийн ахуй, түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд нийгмийн хөгжлийн амаргүй замыг туулж, өнөө үетэй золгох хүртэл үндсэн агуулга, шинж чанар, үнэлэмж, үнэ цэнээ хадгалан үлдэж, Монголын ард түмний амьдралд хүндтэй байр эзэлсэн хэвээр байна. Гэвч монгол аж төрөх ёс, ахуй амьдралын энгийн боловч амин чухал үнэт зүйлсийг орчин цагийн хүмүүс хадгалж, уламжлуулах байтугай үнэ цэн, ач холбогдол, утга учрыг нь мэдэхгүй, тоомсорлохгүй байгаа нь сүүлийн жилүүдэд тод анзаарагдах болов. Энэ талаар “Улс орон, өвөг дээдсийнхээ түүх, уламжлалт өв соёл, зан заншил, урлагаа үл тоох, умартах, бүр үгүйсгэх хандлага хүртэл цухалзаж, гаднын кино, урлагаар дамжсан үзэл суртал, соёл ахуйд их автаж байгаа нь илт анзаарагдах боллоо. Товчхондоо манай иргэдийн оюун санааны дархлаа сул байна гэж би үздэг” гэж засгийн газрын тэргүүн нэгэнтээ хэлсэн нь үндэсний соёл, өв уламжлалаа алдах нь үнэн хэрэгтээ үндэсний үнэт зүйлгүй болох, цаашлаад үндэсний ижилсэлгүй болж гаднын соёлд уусах аюултайг илэрхийлсэн хэрэг.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл

1. Дэлхийн монгол
2. Нүүдлийн соёл иргэншилт монгол
3. Монгол хэл бичиг
4. Үндэсний бахархал, эв нэгдэл
5. Эрдэм судлал, нийгмийн соён гэгээрэл

“Үнэт зүйл” гэсэн ойлголт аливаа улс үндэсний хувьд дотоод мөн чанар, ижилсэл-ондоошил (“national identity”)-той уялдаатай байдаг. Ард түмний оюун санаа, хүсэл эрмэлзэл, дотоод мөн чанарын нэгдлийг олох нь аливаа улс орны хувьд амин чухал асуудал байдаг бөгөөд энэ нь улс орнуудын оршин тогтнох, хөгжин дэвжихийн үндэс болдог. Монголчууд монголоороо аж төрж, бусдаас ялгаран орших чухал хүчин зүйл нь үндэсний соёл гэж үзвэл юуны түрүүнд монгол үндэсний нэгдмэл үнэт зүйлсийг тодорхойлж, түүнийг төрөөс бодлогоор дэмжин цогцлоох нь эн тэргүүний зорилго болно. Хүн төрөлхтний соёл, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт нэгдэн нийлэх үйл явц бий болж, даяаршил нэгэнт бодитой болсон энэ онцлог цаг үед үндэстэн өөрийн төрөлх язгуур шинжээ хадгалах нь тухайн үндэстний оршин тогтнох эсэхийг шийдэх гол арга зам юм. Тухайн улс, үндэстэн, угсаатны соёлын үнэт зүйлд харшлах гаднын соёлын сөрөг хэлбэрийг эсэргүүцэх, түүнээс зайлсхийх, өөрт ашигтай шинэ цагийн соёлд дасан зохицох, хүлээн зөвшөөрөх гэсэн хариу үйлдлүүд буюу үндэсний соёлын дахин давтагдашгүй цогц байдлыг хадгалах чадвар нь соёлын дархлаатай байх боломж юм. Тиймээс үндэстний язгуур шинж, ижилсэл, ондоошлыг хадгалах гол хүчин зүйл нь үндэсний нэгдмэл үнэт зүйл, түүнд тулгуурласан соёлын дархлаа билээ. Хүн ёс, хүн чанар, хууль ёс, мэдлэг боловсрол, ёс суртахуун, тэгш байдал, шударга ёс, эрх чөлөө, эв эе, эрдэм, эв дүй, иргэдийн оролцоо, нийтэд ил тод байх, эрхэмлэх шүтээн, бишрэл, итгэл үнэмшил, эрүүл мэнд, хариуцлагатай байдал, бүтээлч чанар, өөртөө итгэлтэй байдал зэрэг хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг олноор дурдаж болох боловч тусгаар тогтнол бүхий ЭХ ОРОН, газар нутаг, тэнд оршин суугч МОНГОЛ ХҮН, үндэстний дахин давтагдашгүй шинж чанарыг хадгалах НҮҮДЛИЙН АХУЙ, түүнээс урган гарсан ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛ, УРЛАГИЙН БҮТЭЭЛ, орчин үетэй хөл нийлүүлэн хөгжих УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨГС ЗОХИЦОЛ-гүйгээр дээрх бүгд ухвар мөчид болох юм. Нөгөөтээгүүр хувь хүний болон нийгмийн түвшний үнэт зүйлс нь үндэсний онцлогтой нягт уялдаж, эх орны эрх ашиг, монгол хүний онцлог, нүүдлийн ахуй, түүх, соёл, урлагийн бүтээлдээ уламжлал, шинэчлэлийн тэнцвэрт харьцаанд шингэн сүлэлдэж ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ-ийг бүтээх учиртай. Иймд энэ зорилгын хүрэх үр дүнг дараах байдлаар тодорхойллоо. Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хөгжлийн үе шатуудыг тодорхойллоо.

Нүүдлийн соёл иргэншилт монгол

Зорилт 1.2. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

Хүснэгт 3.2. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ӨВ СОЁЛОО ДЭЭДЛЭГЧ СОЁЛЫН ДАРХЛАА БҮХИЙ МОНГОЛ ХҮН	ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ БҮХИЙ АЗИЙН МОНГОЛ	НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ БҮТЭЭГЧ НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ ДЭЛХИЙН МОНГОЛ
Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе	Монголчуудын үндэсний ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе	Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе
1. Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх 2. Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудыг дэмжих 3. Үндэсний сор бүтээл /Brand/, үндэсний шинэлэг бүтээл /con - tent/ зэргийг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээх үйл явцыг өрнүүлэх	1. Үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг тогтвортой бэхжүүлж, уламжлал шинэчлэлийн тэнцвэрт харьцааг хэвшүүлэх 2. Байгаль дэлхийд ээлтэй нүүдлийн соёл иргэншлийн бэлгэ тэмдэг болсон монгол гэрийг сайжруулан хэрэглэхэд хялбар болгон түгээн дэлгэрүүлэх 3. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г өндөр уулын	1. Үндэсний өв соёл, нүүдлийн ахуй бүрэн хамгаалагдаж, уламжлал, шинэчлэлийг хослуулсан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох 2. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-үүдийн үйл ажиллагааг уялдуулж, нүүдлийн соёл иргэншлийн тэргүүлэх улсын түвшинд хүрэх 3. Үндэсний ижилсэл, өв соёлын талаарх ард нийтийн хандлага бүрэн

4.Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төв байгуулах	бүсэд байгуулснаар үндсэн таван бүс бий болж, аажмаар өргөтгөх, эрс өндрийн нүүдлийг сэргээх 4.Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих	төлөвшихөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
--	--	--

Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1.2.1. Монгол гэр бүл бол соёлын төрөл зүйлийг цогцоор нь шингээсэн соёлын голомт учир “Гэр бүл-Монгол соёлын анхдагч орчин” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж “Монгол хүүхэд”, “Монгол гэр бүл”, “Монгол төрийн гэр бүлийн талаарх бодлого” гэсэн гурвалсан холбоо үүсэх юм. Монгол гэр бүлийг уламжлалт соёлын ахуй орчин болохынх нь хувьд төрөөс дэмжих, гэр бүлийн уламжлалт үнэт зүйлсийг хадгална.

1.2.2. Иргэн бүрийг угийн бичигжүүлэх, өвөг дээдэс, угийн хэлхээгээ мэддэг болгохоос гадна иргэний бүртгэлийн мэдээллийн системд угийн хэлхээг тодорхойлон монгол хүний удмын санг хамгаална.

1.2.3. Дэлхийд ховор мал аж ахуйд суурилсан нүүдэлчин соёл, түүний унаган төрхөөрөө хадгалагдан үлдсэн өвөрмөц байдал, олон угсаатны бүлгүүдийн зэрэгцэн орших сонирхол татам соёлын илрэлүүд, хүн амын гарын ур дүй, хийж бүтээх авьяас, нутгийн олон түмний эелдэг найрсаг, зочломтгой зан хийгээд бахархам түүх. Энэ бүгд Монголын аялал жуулчлалын гол дүр төрх мөн. Тиймээс “Өөрсдийн язгуур соёл, түүний өвөрмөц илрэлийг аяллын бүтээгдэхүүн болгохдоо ойлгомжтой, хүртээмжтэй, өөриймсөг, жинхэнэ мөн чанараар нь хүргэхийг урьтал болгож түүндээ санхүү, эд материал, хүн хүчний нөөцийг хангалттай зориулж эцсийн үр дүндээ үндэсний соёлыг гайхан биширч, хүндлэх хандлагыг буй болгох” гэсэн гол өгөөжийг бүтээх, ялангуяа дотоодын жуулчдад үндэсний өв соёл, нүүдлийн ахуйдаа суралцах, түүгээрээ бахархах үзэл төлөвшүүлж, соёлын дархлааг нь дэмжинэ. Нөгөө талаар нүүдлийн соёл, ахуйг хадгалж, тээж яваа малчин өрх, өв соёлоо

дээдлэгч монгол гэр бүлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг дэмжих нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

1.2.4. Боловсролын нэгдсэн тогтолцоо, сургалтын хөтөлбөрт нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, цэцэрлэгт үндэсний өв соёл, уламжлалт тоглоом наадгай хангаж, хүүхэд багачууд, суралцагчдад энэ төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлнэ.

1.2.5. Хүүхэд залуучуудын театр, хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхэд хөгжлийн төвүүдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

1.2.6. Үндэсний ижилсэл, соёлын дархлаатай монгол хүнийг бэлтгэхэд чиглэсэн өв соёлын өргөө, соёлын төвүүд, үндэсний спортын дугуйлангуудын үйл ажиллагааг дэмжих ба Соёлын биет бус өв, язгуур урлагийн шавь сургалтыг бий болгосон бүлэг, хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж, урамшуулах тогтолцоог бий болгоно.

1.2.7. Улс орон даяар үнэт зүйлс, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр гарсан судалгааны үр дүнгээр зорилтот нэвтрүүлгүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлж, үндэсний хэмжээний цуврал лекц, ярилцлага зохион байгуулагчдыг төрөөс дэмжинэ.

1.2.8. “Дэлхийн нүүдлийн соёл, иргэншлийн голомт” байгууллагыг байгуулах, Дэлхийн нүүдэлчдийн төв болох цогц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.

1.2.9. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г бүс нутгийн онцлогт тохируулан байгуулах буюу Говийн бүсэд палеонтологийн задгай музей, хангайн бүсэд археологийн хотууд (Хүннүгийн язгууртны, буган хөшөөний цогцолбор, Өглөгчийн хэрэм, Аваргын балгас г.м.), Хөвсгөл, тайгын бүсэд цаатны отог, дархад бөөгийн отог, Даян дээрхийн агуйн цогцолбор, Монголын Эзэнт гүрний түүх, нүүдэлчдийн өв соёлын онцлогтой “Нүүдэлчин” олон улсын түвшний кино үйлдвэрлэлийн төвийг тус тус байгуулах ба тэдгээрийг дагасан аялал, жуулчлалын хөтөлбөрүүд бий болгож хөгжүүлнэ.

1.2.10. Улаанбаатар хотын хурдны тойрог зам дагуу “Соёл, урлагийн цогцолбор”, Монгол багт бүжгэн жүжгийн театр байгуулах, энэ төрлийн бүжгэн жүжгийн цомнол, бүтээлүүд бий болгох, урлагийн сургалт, уран бүтээлийг үндэсний өв, соёлд түшиглэн орчин цагийн бүтээл /контент/ хөгжүүлэх, судалгааны инкубатор

төвийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулж үйл ажиллагааг нь дэмжинэ.

1.2.11. Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ.

Үндэсний бахархал, эв нэгдэл

Зорилт 1.4. Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.

Хүснэгт 3.3. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040) I	III үе шат (2041-2050)
ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ ДОР ЭВ НЭГДЛИЙГ ДЭЭДЛЭГЧ МОНГОЛ	ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ-ЭВ НЭГДЛИЙН ГАГНААС	НЭГДМЭЛ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, НЯГТАРСАН ЭВ НЭГДЭЛ
Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлэх үе	Үндэсний бахархлыг иргэн бүрийн үйл хэрэгт шингээж, түүнд тулгуурласан үндэсний эв нэгдлийг төлөвшүүлэх үе	Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшиж, эв нэгдэл нягтрах үе
1. Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзэл, үндэсний эв нэгдлийг сэргээх 2.Өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг хөгжүүлэх	1. Археологи, палеонтологийн дурсгалын төрөл зүйлийг эдийн засгийн үнэлгээгээр үнэлэх 2.Дэлхийд өрсөлдөх үндэсний археологич, палеонтологичдыг бэлтгэх, чадамжийг дээшлүүлэх, судлаач, эрдэмтэн бэлтгэх	1. Төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлэх 2.Улс төр, эдийн засаг, нийгэм, шашин зэрэг бүхий л хүрээнд эв нэгдлийг нягтруулахад

<p>3.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд үндэсний онцлогтой болгох</p> <p>4.Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээлүүд, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг сэргээх, биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх</p>	<p>3.Үндэсний болон сонгодог урлагийг түгээгч мэргэжлийн байгууллагуудын барилга байгууламжийн дэд бүтэц, орчин нөхцөл, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хөгжмийн зэмсгээр бүрэн хангаж шинэчлэх</p> <p>4.Үндэсний эв нэгдэл, нийгмийн зөвшилцлийг алдагдуулах эрсдэлийг хянах, түүнээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх</p>	<p>чиглэсэн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх</p>
---	---	---

Нүүдлийн соёл иргэншилт монгол

Зорилт 1.2. Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.

Хүснэгт 3.4. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040) I	III үе шат (2041-2050)
<p>ӨВ СОЁЛОО ДЭЭДЛЭГЧ СОЁЛЫН ДАРХЛАА БҮХИЙ МОНГОЛ ХҮН</p>	<p>ҮНДЭСНИЙ ИЖИЛСЭЛ БҮХИЙ АЗИЙН МОНГОЛ</p>	<p>НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ БҮТЭЭГЧ НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ ДЭЛХИЙН МОНГОЛ</p>
<p>Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх үе</p>	<p>Монголчуудын үндэсний ижилсэл бэхжиж, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе</p>	<p>Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох үе</p>

<p>1. Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх</p> <p>2. Нүүдлийн соёл иргэншлийг хамгаалахад чиглэсэн төрөлжсөн байгууллагуудыг дэмжих</p> <p>3. Үндэсний сор бүтээл /Brand/, үндэсний шинэлэг бүтээл /con - tent/ зэргийг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан бүтээх үйл явцыг өрнүүлэх</p> <p>4. Хүүхдийн соёлын өв, хөгжлийн төв байгуулах</p>	<p>1. Үндэсний үнэт зүйлд суурилсан соёлын дархлааг тогтвортой бэхжүүлж, уламжлал шинэчлэлийн тэнцвэрт харьцааг хэвшүүлэх</p> <p>2. Байгаль дэлхийд ээлтэй нүүдлийн соёл иргэншлийн бэлгэ тэмдэг болсон монгол гэрийг сайжруулан хэрэглэхэд хялбар болгон түгээн дэлгэрүүлэх</p> <p>3. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-г өндөр уулын бүсэд байгуулснаар үндсэн таван бүс бий болж, аажмаар өргөтгөх, эрс өндрийн нүүдлийг сэргээх</p> <p>4. Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, бүтээн үргэлжлүүлэх, өвлөн уламжлах үйл ажиллагаанд оролцогч талуудыг дэмжих</p>	<p>1. Үндэсний өв соёл, нүүдлийн ахуй бүрэн хамгаалагдаж, уламжлал, шинэчлэлийг хослуулсан, нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болох</p> <p>2. “Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн”-үүдийн үйл ажиллагааг уялдуулж, нүүдлийн соёл иргэншлийн тэргүүлэх улсын түвшинд хүрэх</p> <p>3. Үндэсний ижилсэл, өв соёлын талаарх ард нийтийн хандлага бүрэн төлөвшихөд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх</p>
---	--	--

Эрдэм судлал нийгмийн соён гэгээрэл

Зорилт 1.5. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж нийтийн хүртээл болгож хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.

Хүснэгт 3.5. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040) I	III үе шат (2041-2050)
ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА - СОЁН ГЭГЭЭРЭЛ	СУДАЛГААНЫ ҮР ДҮН ТӨР, НИЙГЭМД	ҮНЭТ ЗҮЙЛ БҮХИЙ НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ
Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлүүдийн судалгааг салбар тус бүрээр гүнзгийрүүлэн хийж, нийтийн хүртээл болгох үе	Гүнзгийрүүлсэн судалгааны бүхий л үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үе	Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлээр судалгааны бүхий л үр дүнгийн хэрэгжилт хэвшил болж, нийгмийн соён гэгээрэл өндөр түвшинд хүрэх үе
1. Үнэт зүйлийн суурь, хавсарга болон гүнзгийрүүлсэн судалгааг тогтворжуулах 2. Судалгааны шинэ эх хэрэглэгдэхүүнүүдийг эрэн сурвалжилж, бүртгэн судалгааны эргэлтэд оруулах	1. Техник, технологийн шинэчлэлд тулгуурласан судалгаа шинжилгээний аргуудыг үндэсний үнэт зүйлийн судлалд нэвтрүүлэх 2. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн гүнзгийрүүлсэн судалгааны үр дүнг төр, нийгмийн амьдралд хэрэгжүүлэх үндэсний хэмжээний хөтөлбөр хэрэгжүүлэх	1. Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгааны бүхий л үр дүнг олон нийтийн хүртээл болгож, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэх

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд

Дэлхийн зах зээл дэх үнийн түвшин тогтвортой байх нөхцөлд суурь хувилбараар хийсэн тооцооллоор манай улсын экспорт 2018-2030 онуудад жилд дунджаар 4.2-6.3, импорт 4.0-6.8 хувиар өсөхөөр байна. Дурдсан хугацааны

үргэлжлэлд экспорт 1.71, импорт 1.77 дахин өсөж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр экспорт 13.9 тэрбум ам.долларт, оны үнээр 17.1 тэрбум ам.долларт, импорт 1.77 дахин нэмэгдэж, 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.4 тэрбум ам.долларт, оны үнээр 14.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарав. “Ногоон эдийн засаг” хувилбараар 2018-2030 онуудад экспорт жилд дунджаар 4.0-6.8 хувь, импорт жилд дунджаар 4.1-6.3 хувь, дурдсан хугацааны туршид экспорт 1.69 дахин, импорт 1.75 дахин өсөх тооцоо гарч байна. Ингэснээр 2030 он гэхэд манай улсын экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 13.4 тэрбум ам.долларт, оны үнээр 16.9 тэрбум ам.долларт, импорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 11.3 тэрбум ам.долларт, оны үнээр 14.3 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Харин томоохон төслүүдийг оруулсан тооцоогоор, тэдгээр төслийн нөлөөгөөр экспорт жилд 2.2-31.6 хувь, импорт 3.5-32.9 хувиар өсөж, дурдсан хугацааны туршид экспорт 2.56 дахин, импорт 2.62 дахин өсөх тооцоо гарч байна. 2030 он гэхэд экспорт 2017 оны зэрэгцүүлэх үнээр 20.1 тэрбум ам.долларт, импорт 16.9 тэрбум ам.долларт, оны үнээр экспорт 25.6 тэрбум ам.долларт, импорт 21.5 тэрбум ам.долларт хүрэх тооцоо гарлаа. ЗОРИЛТ 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

Хүснэгт 3.6. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
ТҮҮХИЙ ЭД ЭКСПОРТЛОГЧООС БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТЛОГЧ	ЗҮҮН ХОЙД АЗИЙН ОРГАНИК ХҮНС, ЭРЧИМ ХҮЧНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ	ОЛОН ТУЛГУУРТ ЭДИЙН ЗАСАГТАЙ МОНГОЛ
Эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үе	Хүнд, хөнгөн болон эрчим хүч, барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үе шат луу шилжих үе	Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, олон тулгуурт тогтвортой эдийн засагтай улс болох үе
Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын	Боловсруулах салбар давамгайлсан эдийн засгийн бүтцийг	1. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэлхийн зах зээл дэх

аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх Бүтээлч аж үйлдвэрлэл (соёл урлаг, кино урлаг, дуу хөгжим, дизайн архитектур)-ийн хөгжлийн бодлогын суурийг тавих Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх Эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх	бүрэлдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах Бүтээлч аж үйлдвэрийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлэх	байр суурийг бэхжүүлэх
--	--	------------------------

Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн

Зорилт 4.5 Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 3.7. Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

I үе шат (2020-2030)	II үе шат (2031-2040)	III үе шат (2041-2050)
КЛАСТЕР ХӨГЖИЛ, БҮТЭЭМЖТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	БҮС НУТГИЙН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ИДЭВХТЭЙ ТОГЛОГЧ	ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БРЭНД ҮЙЛДВЭРЛЭЛ
Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацид тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх үе	Бүс нутгийн болон олон улсын чанар, стандартын тогтолцоог нэвтрүүлэх, цахим худалдааг хөгжүүлэх замаар бүс нутгийн нэмүү өртгийн	Технологийн дэвшил, ур чадвартай хүний нөөц, цахим худалдаанд тулгуурлан дэлхийд өрсөлдөх чадвартай, инновацид суурилсан брэнд бүтээгдэхүүн

	сүлжээнд холбогдож ажиллах үе	үйлдвэрлэж, нийлүүлэх үе
<p>1. Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p> <p>2. Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн зарчмаар хөгжих нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>1. Бүс нутгийн эдийн засгийг дэмжих экспортын төрөлжилтийг бий болгох</p>	<p>1. Инновацид суурилсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх</p>

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШИЛТ МОНГОЛ

1	Түүхийн дурвгалт газрууд түүнд түшиглэн олон нийтэд байгаль хамгаалал, уламжлалт ёс заншил мэдлэг төлөвшүүлэх "Нүүдлийн соёл иргэншлийн үндэсний хүрээлэн"-г 5 бүсэд байгуулах	Баруун, Хангай, Төв, Зүүн, Улаанбаатарын бүс	Соёл	БСШУСЯ	2021-2035	30,000,000	Мэдээлэлгүй
2	Палеонтологийн музейн барилга байгууламжийг барих	Дундговь аймаг Сайнцагаан сум	Соёл	БСШУСЯ	2024-2026	60,000,000	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Үндэсний Археологийн музей байгуулах	Төв аймаг Зуунмод хот	Соёл	БСШУСЯ	2022-2024	70,000,000	ТЭЗҮ-гүй, судалгаа хийгдэж байна.

МОНГОЛ ХЭЛ БИЧИГ

1	Хүүхдийн Төв номын сангийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэл	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг	Боловсрол	БСШУСЯ	2022-2023	1,500,000	ТЭЗҮ, судалгаатай
---	---	----------------------------------	-----------	--------	-----------	-----------	-------------------

ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ЭВ НЭГДЭЛ							
1	Монгол туургатны хэл, соёл уламжлалыг хадгалж хөгжүүлэх хөтөлбөр	Дэлхий дахинд	Соёл	БСШУСЯ	2021-2050	26,200,000	Мэдээлэлгүй
2	Хархорум хотын туурийг бэхжүүлэх, сэргээх	Өвөрхангай, Хархорум сум	Соёл	БСШУСЯ	2020-2036	30,000,000	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
3	Үндэсний урлагийн их театрын шинэ барилга барих	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг	Соёл	БСШУСЯ	2020-2022	200,000,000	Зураг төсөл хийгдээгүй
ЭРДЭМ СУДЛАЛ - НИЙГМИЙН СОЁН ГЭГЭЭРЭЛ							
1	Монгол угсаатны үндэсний музейн цогцолбор байгуулах төсөл	Ховд аймаг, Жаргалан сум	Соёл	БСШУСЯ	2026-2028	55,000,000	ТЭЗҮ-гүй, судалгаагүй
2	Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар, номын сангийн шинэ барилга	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг	Соёл	БСШУСЯ	2020-2023	12,000,000	Зураг төсөл хийгдээгүй

ДӨРӨВ. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлбэл соёл, урлагийн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл сайжрах (3.8) ба дэлхийд өрсөлдөх монгол брэнд бий болох -4.0 (сайн), соёлын өвийн үнэ цэнэ өсөх-3.9, дэвшилтэт технологи нэвтрэх, орчин үеийн техник тоног төхөөрөмж ашиглах-3.9, соёлын аялал жуулчлал хөгжих-3.9 зэрэг хүчин зүйлс эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт 4.1. Улс орны хөгжилд үзүүлэх нөлөөллийн харьцуулсан үнэлгээ

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ	
		Соёл урлагийн	Соёлын бүтээлч
1	Дэлхийд өрсөлдөх монгол брэнд бий болох	2.7	4.0
2	Соёлын өвийн үнэ цэнэ өсөх	2.6	3.9
3	Дэвшилтэт технологи нэвтрэх, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглах	2.4	3.9
4	Соёлын аялал жуулчлал хөгжих	2.3	3.9
5	Хүн амыг соён гэгээрүүлэх, соёл урлагаар үйлчлэх	2.8	3.8
6	Олон улсын зах зээлд өрсөлдөж, зах зээл өргөжих	2.0	3.8
7	Соёлын контентын үнэлэмж нэмэгдэх	2.2	3.7
8	Байгууллагын орчин нөхцөл олон улсын жишигт хүрэх	2.1	3.7
9	Онлайн соёлын контент худалдаа хийгдэж, орлого нэмэгдэх	2.1	3.7
10	Бүтээлч бизнесийг дэмжих орчин бүрдэж, өрсөлдөх чадвар сайжрах	2.0	3.7
11	Соёлын ажилтан, уран бүтээлчид хийснээрээ цалин авах, орлого олох	2.1	3.6
12	Зохиогчийн эрхийг лицензийн гэрээгээр арилжих, ашиг хүртэх	2.2	3.4
	Дундаж үзүүлэлт	2.3	3.8

Соёл, урлагийн салбарын улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хангалтгүй (2.3) түвшинд гэж үнэлж, өнөөгийн байдлаар: i) хүн амыг соён гэгээрүүлэх, соёл урлагаар үйлчлэх-2.8, ii) дэлхийд өрсөлдөх монгол брэнд бий болох-2.7, iii) соёлын өвийн үнэ цэнэ өсөх-2.6 зэрэг хүчин зүйлс хамгийн өндөр

үнэлгээтэй байгаа боловч, хангалтгүй түвшинд байгаа нь өнөөгийн соёлын урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны чанар, өгөөж нийгмийн эрэлт, хэрэгцээ хангаж, улс орны хөгжилд үзүүлэх нөлөөлөл нь хангалтгүй байгааг харуулж байна.

Манай улсын хувьд соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн түвшнийг үнэлбэл хөгжмийн урлаг (3.5), бүжгийн урлаг (3.5), зар сурталчилгаа (3.5), сонгодог урлаг (3.3), жүжгийн урлаг (3.2), телевиз (3.0) зэрэг салбаруудын хөгжил харьцангуй өндөр гэжээ. Манай улсад уламжлалт урлагийн төрлүүд харьцангуй сайн хөгжсөн, харин орчин үеийн технологид суурилсан хэв шинжүүд, бүтээлч бизнесийг хөгжүүлэх үйлчилгээ сайн хөгжөөгүй болох нь харагдаж байна. Тухайлбал, бүтээлч бизнесийн зөвлөх үйлчилгээ (2.2), Соёлын төв, энтертайнмент төв (2.2) зэрэг нь хангалтгүй түвшинд байна.

Хүснэгт 4.2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэд салбаруудын хөгжлийн эрчимжилт

№	Чиглэлүүд	Үнэлгэ	№	Чиглэлүүд	Үнэлгэ
1	Хөгжмийн урлаг	3.5	18	Интерьер дизайн	2.7
2	Бүжгийн урлаг	3.5	19	Онлайн худалдаа	2.7
3	Сонгодог урлаг	3.3	20	Соёлын аялал жуулчлал	2.6
4	Жүжгийн урлаг	3.2	21	Эвент арга хэмжээ	2.6
5	Телевиз	3.0	22	Дүрс бичлэгийн үйлчилгээ	2.5
6	Зар сурталчилгаа	3.0	23	Маркетингийн үйлчилгээ	2.5
7	Радио	2.9	24	Гоёл чимэглэл	2.5
8	Кино урлаг	2.9	25	Музей, галерей	2.5
9	Хувцас загвар	2.9	26	График дизайн	2.5
10	Уран зураг	2.9	27	Соёл урлагийн сургалт	2.4
11	Интернэт үйлчилгээ	2.9	28	Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	2.4
12	Компьютер тоглоом	2.9	29	Номын сан	2.4
13	Ном хэвлэл	2.8	30	Зах зээлийн судалгаа	2.3
14	Гар урлал	2.8	31	Энтертайнмент төв	2.3
15	Телевизийн шоу	2.8	32	Соёлын төв, ордон	2.2

16	Видео тоглоом	2.8	33	Менежментийн зөвлөх үйлчилгээ	2.2
17	Дуу бичлэгийн үйлчилгээ	2.7	34		

Манай улсад соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тулгамдсан хүндрэлтэй асуудлуудын хувьд: маркетингийн үйлчилгээ хөгжөөгүй (3.4), энэ талын ойлголт төлөвшөөгүй, салбарт судалгаа ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаа хөгжөөгүй (3.4), Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх туршлага, ур чадвар сул (3.4) гэж тодорхойлогдсон нь манай улсад соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд өнөөгийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, сайжруулахад урьдчилан анхаарах шаардлагатай юм.

Хүснэгт 4.3. Соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгамдаж буй асуудлууд

№	Үзүүлэлтүүд	Үнэлгээ
1	Маркетингийн үйлчилгээ хөгжөөгүй, энэ талын ойлголт төлөвшөөгүй	3.4
2	Салбарт судалгаа ба хөгжүүлэлтийн үйл ажиллагаа хөгжөөгүй	3.4
3	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх туршлага, ур чадвар сул	3.4
4	Зах зээлийн тогтворгүй байдал	3.3
5	Үйл ажиллагаа явуулахад эрх зүйн орчин хүндрэлтэй	3.3
6	Соёл урлагийн байгууллагуудын орчин нөхцөл хэт хоцрогдсон	3.3
7	Технологийн хоцрогдол, хуучралт	3.3
8	Мэргэшсэн хүний нөөц хангалтгүй, хүний нөөцийн чадвар сул	3.3
9	Зах зээлийн судалгаа хийх, монгол хэрэглэгчийг судлах асуудал орхигдсон	3.2
10	Зөвлөх үйлчилгээний ач холбогдол, үнэ цэний талаарх ойлголт сул	3.2
11	Салбарт мэргэжлийн менежер, продюсерүүд хүрэлцээгүй	3.2
12	Салбарын урт хугацааны хөгжлийн бодлого	3.2
13	Дэд бүтцийн хөгжил сул, хэт хоцрогдсон	3.2
14	Авьяаслаг бүтээлч мэргэжилтнүүд өөр салбарт ажиллах хандлагатай	3.2
15	Хямд, үнэгүй барааг илүүд үзэх хэрэглэгчдийн сэтгэлгээтэй	3.0
16	Бусад улсын соёлын агуулга бүхий бүтээгдэхүүний хэт нийлүүлэлт	3.0
17	Үйлдвэрлэгч, хэрэглэгч хоорондын харилцаа хангалттай хөгжөөгүй	3.0

18	Кластерын хөгжил, бүрдүүлэлтэд хөрөнгө оруулалтын эх үүсвэргүй	2.9
19	Хүн амын худалдан авах чадвар муу	2.8
20	Соёл урлагийн байгууллагуудын менежментийн чадавх сул	2.5

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлүүдийг салбарын судлаач, мэргэжилтнүүдийн санал болон төрийн захиргааны төв байгууллагын баримталж буй бодлоготой уялдуулан тодорхойлж, үр дүнг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүд

№	Салбарууд	Ач	№	Салбарууд	Ач холбогдол
Урлагийн тоглолт ба баяр ёслол			Дүрслэх урлаг ба гар урлал		
1	Хөгжмийн үйлдвэрлэл	3.6	17	Гар урлал	3.6
2	Тайзны урлаг	3.4	18	Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл	3.6
3	Сонгодог урлаг	3.4	19	Уран зураг	3.4
4	Бүжгийн урлаг	3.4	20	Гоёл чимэглэл	3.4
Ном ба хэвлэл			Дизайн ба бүтээлч үйлчилгээ		
5	Ном, хэвлэл	3.5	21	Маркетингийн үйлчилгээ	3.8
6	Номын сангийн үйлчилгээ	3.4	22	Зохиогчийн эрхийн үйлчилгээ	3.8
Аудио-визуал интерактив медиа			23	Менежментийн зөвлөх үйлчилгээ	3.7
7	Кино үйлдвэрлэл	3.7	24	Интерьер дизайн	3.5
8	Телевиз	3.6	25	Хувцас загвар	3.4
9	Дүрс бичлэгийн үйлчилгээ	3.5	26	График дизайн	3.4
10	Телевизийн шоу	3.5	27	Зар сурталчилгаа	3.3
11	Дуу бичлэгийн үйлчилгээ	3.4	Бусад салбарууд		
12	Радио нэвтрүүлэг	3.3	28	Соёлын аялал жуулчлал	3.6
13	Интернэт үйлчилгээ	3.3	29	Энтертайнмент төв	3.6

14	Контентын онлайн худалдаа	3.2	30	Музей, галерей	3.5
15	Компьютер тоглоом	3.0	31	Шоу, эвент арга хэмжээ	3.4
16	Видео тоглоом	3.0	32	Соёл урлагийн сургалт	3.4

Дээрх хүснэгтээс харвал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд маркетингийн үйлчилгээ (3.8), зохиогчийн эрхийн үйлчилгээ (3.8), менежментийн зөвлөх үйлчилгээ (3.7), кино урлаг (3.7), хөгжмийн үйлдвэрлэл (3.6), телевиз (3.6), гар урлал (3.6), хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл (3.6), соёлын аялал жуулчлал (3.6), энтертайнмент төв (3.6) зэрэг 10 салбарыг тэргүүлэх салбар гэж болохоор байна.

Оюуны өмч нь хүний оюун ухаанаар бүтээгдсэн шинэ мэдлэг, хүний тархи үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн тул үйлдвэрлэл, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлүүдийг хамруулан авч үздэг. Зохиогчийн эрх нь соёлын бүтээлийг бүтээн туурвиж байгаа хүн бүр тусгай эрхтэй байх төдийгүй өөрийнх нь бүтээлийг бусад хүмүүс ашиглах тохиолдолд хөлс авч, ашиг олох боломжтой болохыг баталгаажуулдаг эрх юм.

Хүснэгт 4.5. Соёл, урлагийн байгууллагуудад зохиогчийн эрхийн зөвшөөрөл авдаг байдал, хувиар

№	Байгууллагууд	Эрх шилжүүлэх гэрээгээр	Лицензийн гэрээгээр	Франчайзинг гэрээгээр	Гэрээ байгуулдаггүй
1	Урлагийн байгууллага	38.4	8.4	14.0	39.2
2	Музей	47.6	7.6	3.8	41
3	Номын сан	46.7	4.4	5.6	43.3
4	Соёлын төв, ордон	29.6	10.7	14.3	45.4
	Дундаж	40.6	7.8	9.4	42.2

Зохиогчийн эрх шилжүүлэх гэрээний дагуу дунджаар 40.6 хувь, лицензийн гэрээгээр 7.8 хувь, франчайзингийн гэрээгээр 9.4 хувь, харин гэрээ байгуулдаггүй

гэсэн 42.2 хувь тус тус байна. Үүнээс харвал гэрээ байгуулдаггүй гэсэн хувь өндөр байгаа бөгөөд үүний шалтгааныг хэрхэн гэрээ байгуулах талаар ойлголт муутай, эсвэл аман тохиролцоогоор зохиогчийн эрхийг шилжүүлэн авдаг гэсэн тайлбарыг өгсөн байна. Судалгаанаас харахад лицензийн гэрээ болон франчайзингийн гэрээ хийдэг эсэхэд 10 хувиас доош байгаа нь онолын судалгаатай уялдуулж үзвэл зохиогчийн эрх нь зохиогчийн өмч бөгөөд эзэндээ орлого оруулах, зардал нөхөх гэсэн үндсэн эдийн засгийн ойлголт гажуудаж байгааг харж болохоор байна.

Хүснэгт 4.6. Соёл, урлагийн байгууллагуудад зохиогчийн эрхэд роляти төлдөг байдал, хувиар

№	Байгууллагууд	Бүтээлийг ашиглах бүрд төлдөг	Бүтээлд нэг удаа төлдөг	Ер нь төлдөггүй	Огт төлдөггүй
1	Урлагийн байгууллага	6.6	33.5	25.7	34.2
2	Музей	6.1	15.0	10.6	68.3
3	Номын сан	13.2	14.6	22.2	50.0
4	Соёлын төв, ордон	13.2	12.3	35.0	39.5
	Дундаж	9.8	18.9	23.4	48.0

Дээрх судалгааны үр дүнгээс харахад дийлэнх хариулт болох огт төлдөггүй, ер нь төлдөггүй гэсэн хариулт 71.4 хувьтай байгаа нь зохиогчийн эрхийг шилжүүлэн авч ашигласны төлөө төлбөр төлдөггүй нь харагдаж байна. Төлбөр төлдөггүй шалтгааныг дурдвал дээрх байгууллагуудад тусгайлсан төсөвт тусгагдаагүй, үнэлгээний систем тодорхойгүй тул хэрхэн үнэлж төлбөр төлөхөө мэдэхгүй гэсэн байна. Үүнээс үзвэл зохиогчийн эрхийн урамшууллын онолын бүтээл ашиглах бүрдээ зохиогчид шагнал урамшуулал олгох гэсэн ойлголт дутмаг байна.

Хүснэгт 4.7. Судалгаанд хамрагдагчдын зохиогчийн эрхийн талаарх ойлголт, хувиар

№	Мэргэжил	Сайн мэднэ	Ер нь мэдэхгүй	Огт мэдэхгүй
1	Мэргэжилтэн	27.1	60.9	12.0
4	Уран бүтээлч	9.0	67.5	23.0
	Дундаж үнэлгээ	18.1	64.2	17.5

Судалгаанд оролцогчдын 64.2 хувь нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн талаар ер нь мэдэхгүй, 17.5 хувь огт мэдэхгүй гэж хариулсан нь бүх шатны боловсролын байгууллагын хөтөлбөрт оюуны өмч, зохиогчийн сургалтын агуулгыг оруулах, мөн соёлын мэргэжилтэн, уран бүтээлчдэд зориулан богино сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Хүснэгт 4.8. Зохиогчийг эрхийн зөрчил үүсэж буй шалтгаан, хувиар

№	Хүчин зүйлс	Мэргэжилтэн	Уран бүтээлч	Дундаж
1	Хууль зүйн мэдлэг дутмаг нь хүндрэлтэй	44.3	46.6	45.5
2	Зохиогч ба уран бүтээлчдийн үл ойлголцол	11.8	28.3	20.1
3	Зөрчигдсөн ч шийдвэрлэж чаддаггүй	26.1	10.5	18.3
4	Хувь хүний ухамсарт үйлдэл, ёс зүй	17.7	14.6	16.2

Судалгаанд оролцогчдын 45.1 хувь нь хууль зүйн мэдлэг дутмаг нь хүндрэлтэй, 20.1 хувь нь Зохиогч ба уран бүтээлчдийн үл ойлголцол үүсдэг 18.1 хувь нь зөрчигдсөн ч шийдвэрлэж чаддаггүй, 16.2 хувь нь хувь хүний ухамсарт үйлдэл, ёс зүйн хандлага гэж тус тус хариулжээ. Соёл, урлагийн байгууллагуудад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн харилцааг журамлах, соёл, урлагийн байгууллагын удирдлага, менежерүүдийг оюуны өмч, зохиогчийн эрхийн сургалтад хамруулах, оюуны өмчийн менежмент хийх ур чадвар олгоход анхаарах нь чухал байна.

ТАВ. СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг ажиллагчдаас авсан судалгааны үр дүнд тулгуурлан 7 үндсэн үзүүлэлтээр чанарын үнэлгээ хийхэд 3.36 буюу дундаж түвшинд байна. Харин байгууллагуудын менежментийн тогтолцооны төлөвшлийг дунд (3.44), үйлчилгээний чанарыг дунд (3.28) тус тус үнэлжээ. Судалгааны үр дүнг нэгтгэн доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5.1. Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ, хувиар

№	Үзүүлэлтүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Чанарын үнэлгээ
1	Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын оновчтой байдал	32.3	47.7	7.0	10.3	2.7	3.82
2	Маркетингийн менежментийг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чадавх	9.2	38.3	37.5	12.4	2.6	3.39
3	Хүний нөөцийн менежментийг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чадавх	10.0	36.8	33.2	11.0	9.0	3.28
4	Санхүүгийн менежментийг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чадавх	8.2	37.5	33.2	14.1	7.0	3.26
Менежментийн тогтолцоо		14.9	40.1	27.7	12.0	5.3	3.44
5	Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцэх байдал	4.1	39.9	43.4	8.6	4.0	3.32
6	Үйлчилгээний чанарын түвшин	6.2	39.8	38.5	9.2	6.3	3.30
7	Уран бүтээл, үзэсгэлэнгийн чанарын түвшин	8.5	32.7	37.5	15.3	6.0	3.22
Үйлчилгээний чанар		6.3	37.5	39.8	11.0	5.4	3.28
Нэгдсэн үнэлгээ		10.6	38.8	33.8	11.5	5.4	3.36

Соёл, урлагийн байгууллагуудын ажлын байрны орчин нөхцөлийг 8 үндсэн үзүүлэлтээр чанарын үнэлгээ хийхэд 3.28 буюу дундаж түвшинд байна. Харин ажлын байрны эрүүд ахуйн нөхцөлийг дунд (3.63), хөдөлмөрийн аюулгүй байдлыг


хангалтгүй (2.92) гэж тус тус үзжээ. Судалгаанд хамрагдсан ажиллагчдын ихэнх хэсэг (91%) нь ажлын гүйцэтгэлд ажлын байрны орчин, нөхцөл чухал гэж хариулжээ. Судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулж доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5.2. Ажлын байрны орчин нөхцөлийн үнэлгээ, хувиар

№	Үзүүлэлтүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Чанар
1	Ажлын байрны гэрэлтүүлгийн нөхцөл	23.3	36.4	26.2	12.1	2.0	3.98
2	Ажлын байрны дулаан хангамжийн нөхцөл	41.8	30.1	16.1	12.0	0.0	3.97
3	Ажлын байрны агааржуулалтын нөхцөл	8.5	19.7	34.3	27.4	10.1	3.67
4	Ажлын байрны дуу чимээний хэвийн нөхцөл	9.8	25.7	33.2	25.1	6.2	2.89
Ажлын байрны эрүүл ахуй		20.9	28.0	27.5	19.2	4.6	3.63
5	Ажлын багаж, хэрэгслийн хангалтын байдал	2.1	24.6	48.2	22.0	3.1	3.08
6	Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангасан байдал	1.3	28.3	47.1	14.2	9.1	3.01
7	Ажил үүргээ хэвийн гүйцэтгэх боломж бүрдсэн байдал	2.1	10.3	40.4	43.0	2.2	2.99
8	Ажлын байрны тав тухтай байдал	1.1	20.7	41.2	33.3	3.7	2.61
Хөдөлмөрийн аюулгүй байдал		1.7	21.0	44.2	28.1	4.5	2.92
Нэгдсэн үнэлгээ		4.9	22.1	41.4	26.6	4.5	3.28


Манай улсын хувьд УИХ-аас 2008 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийг батлан хэрэгжүүлж байна. Харин соёл, урлагийн байгууллагуудад энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 41.9 хувь нь тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт ажлын шаардлага хангахгүй, 34.1 хувь нь хариуцсан ажлаа хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж дутагдалтай байдаг гэж хариулжээ.



Зураг 5.1. Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамж, хувиар

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 85 хувь нь ажиллагчдад шинэ санаачилга гаргах сонирхол байдаг ч санхүүжилт хүндрэлтэй (85%), урамшуулал байхгүй (67%), удирдлагын зүгээс дэмждэггүй (71%) тул байгууллагад бүтээлч байдал, инновацийг дэмжсэн үйл ажиллагаа бараг байхгүй (87%) гэж хариулсан нь соёл, урлагийн байгууллагуудад инновацийн соёл төлөвшөөгүй, энэ талын ойлголт хангалтгүй (75%) байна. Судалгааны үр дүнг доорх зурагт харуулав.



Зураг 5.2. Инноваци, бүтээлч байдалд хандах хандлага, хувиар


Соёл, урлагийн байгууллагын хөдөлмөрийн харилцааны өнөөгийн байдлыг 3 бүлэг 12 үзүүлэлтээр чанарын үнэлгээ хийхэд 3.13 буюу дундаж түвшинд байна. Судалгаанд оролцогчид нь ажиллагчдын сэтгэл ханамжийн түвшнийг дунд (3.47), ажиллагчдын ур чадварыг дунд (3.63), харин хөдөлмөрийн үнэлэмжийг муу (2.28) гэж тус тус үнэлжээ.

Хүснэгт 5. 3. Хөдөлмөрийн харилцааны үнэлгээ, хувиар

№	Үзүүлэлтүүд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Чанарын оноо
1	Хамт олны харилцаа, уур амьсгал	16.6	50.3	30	3.1	0.0	4.15
2	Ажилдаа сэтгэл хангалуун байдал	10.9	51.4	26.7	11.0	0.0	3.62
3	Мэргэжилээрээ өсөж хөгжих боломж	12.3	21.2	37.8	24.0	4.7	3.12
4	Удирдлагын арга барил, манлайлал	4.6	28.2	41.1	14.0	12.1	2.99
Ажиллагчдын сэтгэл ханамж		11.1	37.8	33.9	13.0	4.2	3.47
5	Ажил үүргийн тодорхой байдал	0.0	18.3	27.4	40.3	14.0	2.50
6	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ ба урамшууллын уялдаа	2.1	7.9	25.2	54.3	10.5	2.37
7	Цалин хөлсний түвшин, хүрэлцээ	0.0	6.8	27.2	47.4	18.6	2.22
8	Нийгмийн хамгаалал, дэмжлэг	7.2	25.3	36.1	25.3	6.1	2.02
Хөдөлмөрийн үнэлэмж		2.3	14.6	29.0	41.8	12.3	2.28
9	Хамт олны мэргэжлийн ур чадвар	14.0	56.0	25.0	3.0	2.0	3.77
10	Өөрийн ур чадвар, арга барил	27.0	30.0	34.0	9.0	0.0	3.75
11	Хамт олны ажилдаа хандах хандлага	5.0	76.0	19.0	20.0	0.0	3.55
12	Удирдлагын мэргэжлийн ур чадвар	12.0	46.0	23.0	14.0	5.0	3.46
Ажиллагчдын ур чадвар		14.5	52.0	25.3	11.5	1.8	3.63
Нийт үнэлгээ		9.3	34.8	29.4	22.1	6.1	3.13

Судалгаанд хамрагдсан ажиллагчдын 45 хувь нь одоогийн урамшууллын систем нь идэвхжүүлэх хөшүүрэг болдоггүй, 85.8 хувь нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээний системийг өөрчлөх шаардлагатай, 67 хувь нь хүний нөөцийн мэргэшсэн менежер байхгүй, 48.3 хувь нь манай байгууллагад хүний нөөцийн бодлого байхгүй

гэж тус тус хариулжээ. Харин хамт олны харилцаа, уур амьсгалыг сайн (4.15) гэсэн боловч удирдлагын арга барил, манлайллыг муу (2.99) гэж үнэлсэн нь соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтнуудын удирдахуйн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд анхаарах цаг болжээ.




Зураг 5.3. Соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавхын үнэлгээ

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэхэд, соёл, урлагийн байгууллагын менежментийн чадавхыг 7 хүчин зүйлээр чанарын үнэлгээг хийхэд 3.24 буюу дунд түвшинд байна.

Соёл, урлагийн салбарт төрөөс баримтлах социалист системийн бодлого, арга барил өнөөг хүртэл ерөнхийдөө хэвээр хадгалагдаж байгаагаас салбарт зах зээлийн өрсөлдөөнт байдлыг алдагдуулжээ. Улмаар салбарт эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болох өрсөлдөөний таатай орчин бүрдээгүй, түүний төгс бус хэлбэрүүд бий болсноос байгууллагын удирдлагын зүгээс өргөн хүрээнд инновацийг хэрэгжүүлж, маркетингийн идэвхтэй үйл ажиллагаа явуулах, дэвшилтэт технологи нутагшуулах, чадварлаг мэргэжилтнүүдийг ажиллуулах, өрсөлдөхүйц брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох байдлаар өрсөлдөх давуу талыг олж авахын төлөө хүчин чармайлт гарган ажиллах явдал хангалтгүй байдалтай байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас салбарын ихэнх байгууллагуудын менежментийн чадавх сул, зах зээлд өрсөлдөх чадваргүй зэрэг идэвхгүй байдлаас гарах гол арга замын нэг бол бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэмээн үзэж байна. Иймээс соёл, урлагийн байгууллагууд ирээдүйн зорилтот төлөв байдалд хүрэхэд чиглэсэн өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний соёлыг 4 үзүүлэлтээр хэрэглэгч болон ажиллагчдын үнэлгээний зөрүүгээр үнэлж, үр дүнг доорх зурагт харуулав.



Зураг 5.4. Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний соёлын үнэлгээ

Дээрх зургаас харвал, соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний соёлыг ажиллагчид дунд (3.25 – 3.51), хэрэглэгчид муу (2.68 – 2.97) гэж тус тус үнэлжээ. Харин үнэлгээний зөрүү нь 0.54 – 0.76 байна.


Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний орчин нөхцөлийг 8 үзүүлэлтээр хэрэглэгч болон ажиллагчдын үнэлгээний зөрүүгээр үнэлж, үр дүнг доорх зурагт харуулав.



Зураг 5.5. Соёл, урлагийн байгууллагын орчин нөхцөлийн үнэлгээ

Дээрх зургаас харвал, соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний орчин нөхцөлийг ажиллагчид дунд (2.51 – 3.09), хэрэглэгчид муу (2.36 – 3.13) гэж тус тус үнэлжээ. Харин үнэлгээний зөрүү нь 0.04 – 0.72 байна. Иймээс байгууллагын орчин нөхцөлийг хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн бүтээлч байдлаар шинэчлэх шаардлагатай болжээ.

Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанарыг 7 үзүүлэлтээр хэрэглэгч болон ажиллагчдын үнэлгээний зөрүүгээр үнэлж, үр дүнг доорх зурагт харуулав.



Зураг 5.6. Соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанарын үнэлгээ

Дээрх зургаас харвал, соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний чанарыг ажиллагчид сайн (3.85 - 4.45), хэрэглэгчид муу (2.43 - 2.83) гэж тус тус үнэлжээ. Харин үнэлгээний зөрүү нь 1.11 – 1.71 байна. Ер нь соёл, урлагийн байгууллагуудад үйлчилгээний чанарын хөндлөнгийн үнэлгээний системийг нэвтрүүлэх шаардлагатай болжээ.

Хүснэгт 5.4. СУБ-д мэргэшсэн хүний нөөцийн тогтвортой ажиллах нөхцөл, хувиар

№	Үзүүлэлтүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Ажиллагчдын цалинг нэмэгдүүлэх	61.9	59.0	65.0	63.7	46.7	63.4
2	Ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх	6.9	14.7	6.6	4.6	33.3	7.3
3	Ажиллагчдыг орон сууц, байраар хангах	7.3	3.8	7.9	7.7	0.0	7.3
4	Ажиллагчдын нийгмийн баталгааг хангах	9.3	8.3	6.8	5.9	0.0	7.0
5	Мэргэжлийн түвшинд менежмент хэрэгжүүлэх	4.5	7.1	3.9	11.3	13.3	6.2
6	Мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бий болгох	4.0	3.2	6.5	3.3	6.7	5.0
7	Үр дүнд суурилсан үнэлгээний систем бий болгох	6.1	3.8	3.3	3.6	0.0	3.8

Судалгаанд оролцогчид соёл, урлагийн байгууллагад мэргэшсэн хүний нөөц тогтвортой ажиллах нөхцөлийг 63.4% нь ажиллагчдын цалинг нэмэгдүүлэх, 7.3% нь ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх болон орон сууц, байраар хангах гэж хариулжээ.

**Хүснэгт 5. 5. СУБ-д мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэхэд тулгардаг бэрхшээл,
хувиар**

№	Үзүүлэлтүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Үндсэн цалин бага	23.1	25.0	23.9	22.3	20.0	23.4
2	Байгууллагад хүний нөөцийн нэгдсэн бодлого, стратеги байхгүй	19.0	16.7	20.0	20.2	26.7	19.6
3	Байгууллагад хүний нөөцийн мэргэшсэн менежер байхгүй	13.4	20.5	9.2	12.8	0.0	11.8
4	Мэргэжилтэй боловсон хүчин хөдөө ажилладаггүй	15.0	2.6	10.7	7.9	46.7	10.2
5	Байгууллагад ажилтан шинээр ажилд авахад улс төр нөлөөлдөг	6.5	5.1	8.5	5.1	0.0	6.9
6	Нийгмийн баталгаа хангах боломжгүй	4.9	5.8	6.1	9.7	0.0	6.7
7	Орон тоо цөөн	7.7	7.1	6.0	5.9	0.0	6.3
8	Байгууллагад ажиллах орчин нөхцөл муу	0.8	5.1	6.0	6.4	0.0	5.1
9	Бусад	9.7	12.2	9.6	9.7	6.7	9.9

Судалгаанд оролцогчид соёл, урлагийн байгууллагад мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэхэд тулгардаг хүндрэлтэй асуудлыг 23.4% нь үндсэн цалин бага, 19.6% нь байгууллагад хүний нөөцийн нэгдсэн бодлого, стратеги байхгүй, 11.8% нь байгууллагад хүний нөөцийн мэргэшсэн менежер байхгүй гэж хариулжээ.

Хүснэгт 5.6. СУБ-аас мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хамтын ажиллагааны хэлбэрүүд (давхардсан тоогоор), хувиар

№	Үзүүлэлтүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр зарлах байдлаар мэргэшсэн ажиллагчдыг бэлтгэх	75.3	75.6	72.0	85.4	93.3	76.4
2	Байгууллага дээрээ боловсролын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах	48.6	43.6	44.5	41.4	0.0	43.9
3	Сургалт - үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх	40.5	41.0	47.6	36.8	13.3	42.8
4	Байгууллага дээрээ оюутнуудыг цалинтай дадлага хийлгэх байдлаар хүний нөөц бүрдүүлэх	35.6	39.7	35.9	36.3	93.3	36.9

Судалгаанд оролцогчид мэргэшсэн хүний нөөцийн бэлтгэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран ажиллах боломжийг 76.4% нь оюутнуудад зориулсан тэтгэлэгт хөтөлбөр зарлах байдлаар мэргэшсэн ажиллагчдыг бэлтгэх гэж хариулжээ. Харин байгууллагуудын хувьд: i) Байгууллага дээрээ боловсролын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулахыг музей (48.6%), номын сан (43.6%), урлагийн байгууллага (41.4%), ii) Сургалт - үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг соёлын төв (47.6%), iii) Байгууллага дээрээ оюутнуудыг цалинтай дадлага хийлгэх байдлаар хүний нөөц бүрдүүлэхийг БСУГ (93.3%) тус тус чухалчилж үзжээ.

Хүснэгт 5.7. СУБ-ын ажиллагчид сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлэлт, хувиар

№	Үзүүлэлтүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Огт хамрагдаагүй	39.3	42.9	45.3	43.2	46.7	43.6
2	1 удаа хамрагдсан	24.7	31.4	26.9	28.6	26.7	27.4

3	2 удаа хамрагдсан	13.8	9.0	11.4	10.5	13.3	11.3
4	3 удаа хамрагдсан	13.4	9.0	10.0	10.0	13.3	10.5
5	Жил бүр хамрагддаг	8.9	7.7	6.4	7.7	0.0	7.2

Судалгаанд оролцогчид сүүлийн 5 жилд мэргэжил дээшлүүлсэн (сургалт) байдлыг 43.6% нь огт хамрагдаж байгаагүй, 27.4% нь нэг удаа хамрагдсан, 11.3% нь хоёр удаа хамрагдсан, 10.5% нь гурван удаа хамрагдсан, 7.2% нь жил бүр хамрагддаг гэж хариулжээ.

Хүснэгт 5.8. СУБ-ын ажиллагчид мэргэжил дээшлүүлэхэд тулгардаг бэрхшээл, хувиар

№	Үзүүлэлтүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Цалин бага тул сургалтын төлбөр төлөх боломжгүй	68.0	69.3	73.8	74.4	46.7	72.3
2	Байгууллагаас дэмжлэг байхгүй	17.0	16.0	7.2	9.5	53.3	10.1
3	Сургалттай холбоотой мэдээлэл дутмаг	6.1	3.2	3.9	4.9	0.0	4.4
4	Ажлын ачаалал ихтэй учраас мэргэжил дээшлүүлэх боломжгүй	2.4	3.2	2.5	7.4	0.0	3.7
5	Байгууллагад сургалттай холбоотой төсөв байхгүй	2.8	3.8	3.9	2.6	0.0	3.4
6	Багш нарын мэргэжлийн ур чадвар сул	1.2	1.3	3.4	0.3	0.0	2.0
7	Сургалтын хугацаа урт байдаг тул хүндрэлтэй байдаг	0.8	1.9	3.0	0.0	0.0	1.8
8	Орон нутагт амьдардаг тул сургалтад суухад хүндрэлтэй	1.6	1.3	2.3	1.0	0.0	1.8

Судалгаанд оролцогчдын 72.3% нь цалин бага тул сургалтын төлбөр төлөх боломжгүй, 10.1% нь байгууллагаас дэмжлэг байхгүй, 4.4% нь сургалттай холбоотой мэдээлэл дутмаг гэж хариулжээ. Харин аймгийн БСУГ-ийнхан байгууллагын дэмжлэг байхгүй (53.3%), бусад байгууллагууд цалин бага тул сургалтын төлбөр төлөх боломжгүй (68-74.4%) гэдгийг онцолжээ.

**Хүснэгт 5.9. СУБ-ын ажиллагчдын сургалтын хэрэгцээ (давхардсан тоогоор),
хувиар**

№	Сургалтын төрлүүд	Музей	Номын сан	Соёлын төв	Театр, чуулга	БСУГ	Дундаж
1	Маркетинг, зах зээлийн судалгааны сургалт	95.1	60.9	69.6	93.4	0.0	77.9
2	Менежмент, манлайллын сургалт	91.1	76.9	52.7	95.9	66.7	71.9
3	Гадаад хэлний сургалт	74.9	48.1	42.9	53.7	33.3	51.0
4	Соёлын өвийн сургалт	93.1	48.1	52.0	19.2	100	50.4
5	Албан хэрэг, архивын сургалт	52.6	44.9	44.2	38.4	66.7	44.4
6	Мэргэжлийн ур чадварын сургалт	0.0	0.0	41.0	76.7	0.0	39.0
7	Компьютерын сургалт	32.4	96.2	41.6	15.3	33.3	39.0
8	Бакалаврын зэргийн сургалт	2.0	32.1	58.5	6.4	0.0	33.6
9	Хууль, эрх зүйн сургалт	32.4	22.4	24.1	25.6	0.0	25.3
10	Бүтээлч үйлдвэрлэлийн сургалт	4.0	9.6	19.5	53.7	33.3	24.7
11	Соёлын бодлого, эрх зүйн сургалт	4.0	19.2	36.4	1.3	100	21.5
12	Хувь хүний хөгжлийн сургалт	16.2	16.0	14.3	16.6	0.0	15.2
13	Магистрын зэргийн сургалт	2.0	25.6	3.3	3.8	66.7	6.0

Судалгаанд оролцогчид цаашид шаардлагатай сургалтын хэрэгцээг 77.9% нь маркетинг, зах зээлийн судалгааны сургалт, 71.9% нь менежмент, манлайллын сургалт, 51% нь гадаад хэлний сургалт, 50.4% нь соёлын өв (биет, биет бус)-ийн сургалт, 44.4% нь албан хэрэг хөтлөлт, архивын сургалт, 39% нь мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт, 39% нь компьютерын сургалт гэж тодорхойлжээ.




Тайлбар: 5-маш сайн, 4-хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-маш муу

Зураг 5.7. Ажиллагчдын ур чадвар, хандлагын үнэлгээ

Судалгаанд хамрагдсан соёл, урлагийн байгууллагын удирдах ажилтнуудаас ажиллагчдын ур чадвар, хандлагыг 15 үзүүлэлтээр үнэлүүлж, зөрүүний шинжилгээ хийхэд ажил олгогчдын хүсэж буй ур чадвар, хандлагын түвшин 4.13-4.97, ажиллагчдын өнөөгийн ур чадвар түвшин 3.16-3.97, харин гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийн хувьд хангалтгүй байна. Энэхүү ур чадварын зөрүүг арилгахын тулд соёл, урлагийн байгууллагууд хүний нөөцийн сургалт, хөгжлийн хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай болсныг харуулж байна.


ЗУРГАА. МОНГОЛ ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ

Хүн амын амралт чөлөөт цагаа өнгөрүүлдэг хэв шинжийг хэрэглэгчийн судалгааны үр дүнд тулгуурлан тодорхойлж, доорх зурагт харуулав.



Зураг 6.1. Хүн амын амралт чөлөөт цагаа өнгөрүүлдэг байдал (давхардсан тоогоор), хувиар


Дээрх зургаас харвал, судалгаанд оролцогчдын ихэвчлэн амралт, чөлөөт цагаа гэр бүлээрээ өнгөрүүлдэг хэлбэрийн хувьд: гэртээ гэж 91,5 хувь, энтертайнмент төвд гэж 55,8 хувь, фитнес клубт гэж 54,8 хувь, эвент холлд гэж 52 хувь, караокед гэж 47,7 хувь, аяллын клубт гэж 43 хувь, спорт зааланд гэж 40.3 хувь нь тус тус хариулжээ. Сүүлийн жилүүдэд хүн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх идэвхтэй, бүтээлч чөлөөт орчин нөхцөлийг чухалчлах болжээ. Иймээс соёл, урлагийн байгууллагууд хүн ам гэр бүл, найз нөхдөөрөө чөлөөт цагаа өнгөрүүлэхэд чиглэсэн орчин, үйлчилгээ бий болгох шаардлагатай байна.



Зураг 6.2. Хүн амын нэг удаагийн амралт, чөлөөт цагийн үйлчилгээнд дунджаар зарцуулдаг мөнгө (мян.төг), хувиар


Дээрх зургаас харвал, судалгаанд оролцогчдын 16.8% нь ямар нэг төлбөр төлдөггүй, 22.3 хувь 41-60 мян.төг, 18 хувь нь 21-40 мян.төг-ийг нэг удаагийн амралт, чөлөөт цагтаа зориулдаг гэж хариулжээ.

Харин судалгаанд оролцогчид соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэх давтамж нь сард 1 удаа гэж 31.3 хувь, улиралд 1 удаа гэж 24.8 хувь, хагас жилд 1 удаа гэж 13.6 хувь нь тус тус хариулжээ.



Зураг 6.3. Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлдэг давтамж, хувиар

Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлдэг давтамжид нөлөөлөх хүчин зүйлийг нарийвчлан фактор шинжилгээ хийхэд 1 удаа үйлчлүүлэхэд зарцуулах мөнгөн дүн (0.74), үйлчлүүлэгчийн нас (0.57) хамгийн ихээр нөлөөлдөг байна. Иймээс соёл, урлагийн байгууллагууд зах зээлийг оновчтой сегментчилж, сегмент бүрийн онцлог байдалд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох нь чухал юм.



Зураг 6.4. Сонирхдог соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүд (давхардсан тоогоор), хувиар


Дээрх зургаас харвал, судалгаанд оролцогчдын ихэвчлэн сонирхдог соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд i) уран сайхны кино гэж 91.3 хувь, ii) хошин урлагийн тоглолт гэж 68.7 хувь, iii) шоу тоглолт гэж 39.5 хувь нь тус тус хариулжээ.

Судалгаанд оролцогчид соёл урлагтай холбоотой (байгууллага, үзвэр, үйлчилгээ) мэдээллийг ихэвчлэн социал медиагаас авдаг гэж 86.4 хувь, телевизээс гэж 61.9 хувь, найз нөхөд хамаатан салдангаас гэж 58.0 хувь нь тус тус хариулжээ.



Зураг 6.5. Судалгаанд оролцогчдын мэдээлэл авдаг эх үүсвэр (давхардсан тоогоор), хувиар

Судалгаанд оролцогчдын ихэвчлэн үйлчлүүлдэг соёл, урлагийн байгууллагын хувьд, 63.9 хувь кинотеатр, 26.8 хувь нь соёлын төв, ордон (соёлын төв өргөө), 25.2 хувь театр, чуулга гэжээ.




Зураг 6.6. Ихэвчлэн үйлчлүүлдэг соёл урлагийн байгууллага (давхардсан тоогоор), хувиар

Хүн амын соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэхээс татгалздаг үндсэн шалтгааныг хэрэглэгч болон ажиллагчдын үнэлгээг харьцуулан тодорхойлбол.


Үүнд:

- ✚ Олон талт үйлчилгээ байхгүй -88.0 хувь (хэрэглэгч -82.3%, ажилтан -93.7%),
- ✚ Тоног төхөөрөмж хоцрогдсон -75.5 хувь (хэрэглэгч -76,6%, ажилтан -74.4%),
- ✚ Дотор орчин тав тухгүй -68.9 хувь (хэрэглэгч -72,9%, ажилтан -65.0%),
- ✚ Гадна орчны тохижилт муу -58.4 хувь (хэрэглэгч -70.0%, ажилтан -46.7%),
- ✚ Гэр бүлээрээ үйлчлүүлэхэд тохиромжгүй -52.4 хувь (хэрэглэгч -62.7%, ажилтан -42.1%),
- ✚ Үйлчилгээний соёл муу -57.0 хувь (хэрэглэгч -54,0%, ажилтан -60.0%),



Зураг 6.7. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэхээс татгалздаг шалтгаан (давхардсан тоогоор), хувиар

Иймээс соёл, урлагийн байгууллагууд хүн ам гэр бүл болон найз нөхдөөрөө амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэхэд чиглэсэн орчин нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн судалгаа хийх замаар одоогийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай болжээ.




Зураг 6.8. Судалгаанд оролцогчдын ургийн овгоо сонгосон байдал

Судалгаанд оролцогчдын 42% (905) нь ургийн овгоо мэддэг байсан, 25.4% (547) нь удам судраа судалж тогтоосон, 12.6% (271) нь ургийн овгоо шинээр зохиосон гэжээ.



Зураг 6.9. Судалгаанд оролцогчдын өөрөөсөө дээш хэдэн үе мэддэг байдал

Судалгаанд оролцогчдын 79.3% (1711), 3-4 үе мэддэг ба 10.7% (5-6) үе мэддэг бөгөөд, хариулаагүй 6.7 (145), 3.2% (70) 7-8 үеэ мэддэг байна. Зураг 3.2-ыг боловсролтой харьцуулж үзвэл 3-4 үеэ 862 хүн, 5-6 үеэ 110 хүн 7-8 үеэ 41 хүн тус тус мэддэг бөгөөд эдгээр хүмүүс нь бүгд дээд боловсролтой хүмүүс байна.




Зураг 6.10. Угийн бичиг хөтөлдөг байдал

Судалгаанд оролцогчдын 73.1% (1577) нь үгүй цаашид хөтлөх бодолтой байгаа, 18.4% (396) нь тийм, 6.4% (138) нь хөтлөх шаардлагагүй гэж хариулсан байна.




Зураг 6.11. Хуримын ач холбогдол

Судалгаанд оролцогчдын 39.2% (846) нь гэр бүлийн тогтвортой байдлыг бий болгох, 26.8% (579) нь гэрлэж буй хосын ирээдүйн амьдралд сайн сайхныг бэлгэдэх, хүндэтгэх 22.3% (482) нь ардын ёс заншил, өв уламжлалыг хадгалах уламжлуулах зорилгоор хуримыг хийдэг гэж хариулсан байна.




Зураг 6.12. Гэрлэлтийн байдал

Судалгаанд оролцогчдын 34.7% (749) нь хүүхэд төрөхөөс өмнө бэр гуйж, хурим хийсэн, 16.9% (365) нь хариулаагүй, 16.2 (350) нь ёс жаяг баримтлалгүй шууд нэг гэрт орсон гэжээ.



Зураг 6.13. Гэр бүлийн хамгийн эрхэм зүйл

Судалгаанд оролцогчдын 72.9% (1826) нь үр хүүхэд хань ижил, эцэг эх, 10.4% (261) нь итгэлцэл, 6.7% (168) нь хайр сэтгэл, 4.6% (116) нь боловсрол, 3.4% (87) нь мөнгө санхүү, 0.7% (18) нь бэлгийн харилцаа гэж хариулсан байна.



Зураг 6.14. Өдөрт ямар төрлийн нэвтрүүлэг үздэг эсэх

Судалгаанд оролцогчдын 27.5% (1369) нь мэдээ, 11.7% (581) нь уран сайхны кино, 11.0% (548) нь цэнгээнт нэвтрүүлэг, 10.9% (543) нь танин мэдэхүйн нэвтрүүлэг, 9.7% (482) нь телевизийн гадаад кино, 9.6% (477) нь хүүхдийн нэвтрүүлэг, 7.4% (370) нь үндэсний ёс заншил, уламжлалт нэвтрүүлэг, 6.4% (319) нь спортын нэвтрүүлэг, 4.9% (245) нь телевизийн олон ангит цуврал монгол кино, 0.8% (40) нь бусад гэж хариулсан байна.



Зураг 6.15. Эцэг, эхтэйгээ ямар холбоотой байдаг эсэх

Судалгаанд оролцогчдын 54.4% (1174) нь байнга холбоотой байж сэтгэл санаа, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, 16.5% (356) нь хариулаагүй, 12.2% (264) нь тэмдэглэлт өдрүүдээр л хамт байж бэлэг өгдөг, 7.4% (160) нь өөрийнхөө гэрт байлгаж бүх талаар тэтгэж дэмждэг, 5.9% (128) нь холбоотой байдаггүй, 3.5% (75) нь гэрлэсэн ч эцэг эхийнхээ гэрт амьдарч тэдний дэмжлэгийг авдаг гэж хариулсан байна.




Зураг 6.16. Гэр бүлээсээ салсан шалтгаан

Судалгаанд оролцогчдын 24.2% (85) нь зан харьцаа, 17.9% (63) нь архидалт, 14.5% (51) нь итгэл алдалт, 12.0% (42) нь итгэл алдалт, 8.0% (28) нь эдийн засаг, 5.4% (19) нь гэр бүлийн дарамт, хүчирхийлэл, 4.0% (14) нь боловсролын түвшин, дагавар хүүхэдтэй нь таарамжгүй, хардалт, 3.4% (12) нь гэр оронгүй улмаас 2 тусдаа амьдардаг, 2.6% (9) нь нөхөр, эхнэрийн аль нэг нь удаан хугацаагаар хол байснаас гэж хариулсан байна.




Зураг 6.17. Ямар төрлийн хоол түлхүү хэрэглэдэг

Судалгаанд оролцогчдын 57.2% (1234) нь монгол үндэсний хоол, цөөн тохиолдолд бусад үндэстний хоол, 30.4% (656) нь үргэлж монгол үндэстний хоол, 6.1% (132) нь ихэвчлэн бусад үндэстний хоол, цөөн тохиолдолд монгол үндэстний хоол, 4.1% (88) нь хариулаагүй, 1.2% (25) нь бусад гэж хариулсан байна.




Зураг 6.18. Баяр ёслол, тэмдэглэлт өдрөөр хаана, ямар хоол иддэг

Судалгаанд оролцогчдын 75.7% (1633) нь гэртээ үндэсний уламжлалт хоол, 8.1% (174) нь гадуур ази хоол, 4.8% (103) нь гэртээ ази үндэстний хоол, 3.8% (83) нь гадуур европ хоол, 3.7% (80) нь хариулаагүй, 2.1% (46) нь гэртээ орос, европ хоол, 1.8% (38) нь бусад төрлийн хоол хүнс хэрэглэдэг байна.



Зураг 6.19. Мэндлэх ёсноос хэвшсэн байдал

Судалгаанд оролцогчдын 41.1% (1197) нь өдөр тутмын, 21.6% (630) нь цаг улиралтай холбоотой, 15.2% (444) нь биесийн амар мэндийг асуусан, 11.4% (333) нь баяр ёслолын, 7.9% (231) нь ажил үйлтэй холбоотой, 1.8% (52) нь аль нь ч хэвшээгүй, 0.9% (25) нь хариулаагүй гэж хариулсан байна.




Зураг 6.20. Цээрлэх ёсноос мөрддөг эсэх

Судалгаанд оролцогчдын 45.4% (1276) нь ахуй амьдралд холбогдох, 23.2% (653) нь хүмүүс хоорондын харилцаанд холбогдох, 13.1% (367) нь эд зүйлтэй холбоотой, 8.5% (238) нь мал аж ахуйтай холбоотой, 6.0% (169) нь цээрлэх ёсны тухай мэдэхгүй, 3.8% (106) нь бусад гэж хариулсан байна.




Зураг 6.21. Насан өөд болоход хойдохынх ажлыг ямар зан үйлээр хийдэг

Судалгаанд оролцогчдын 81.2% (1752) нь бурхны шашны ламаас асууж, бурхны шашны зан үйлээр хийдэг, 10.0% (216) нь ахмад настнаасаа асууж, гэр бүлийнхээ уламжлалаар, 5.5% (118) нь хариулаагүй, 1.5% (33) нь бөөгөөс асууж, бөөгийн зан үйлээр, 1.0% (21) нь бусад гэж хариулсан байна.




Зураг 6.22. Хүүхдээ хүмүүжүүлэхдээ ардын аман зохиол, сургаалуудын төрлүүдээс ашигладаг байдал

Судалгаанд оролцогчдын 17.6% (1017) нь үлгэр домог, 17.0% (983) нь зүйр цэцэн үг, 15.3% (887) нь онъсого, 11.3% (656) нь ертөнцийн гурав, 8.6% (497) нь түргэн хэллэг, 6.3% (366) нь таавар, 6.0% (348) нь магтаал, 5.9% (340) нь ерөөл, 5.3% (304) нь дайралцаа үг, 4.1% (239) нь алийг нь ч ашиглаж хэвшээгүй, 2.6% (150) нь тууль гэж хариулсан байна.




Зураг 6.23. Ихэвчлэн тоглуулдаг тоглоом

Судалгаанд оролцогчдын 43.3% (1235) нь уламжлалт тоглоом наадгай, 34.0% (969) нь хөлөгт тоглоом, 13.5% (384) нь орчин үеийн үйлдвэрийн тоглоом, 5.7% (163) нь компьютер тоглоом, 3.4% (98) нь бусад гэж хариулсан байна.



Зураг 6.24. Үндэсний дээл хувцсыг ямар үед хэрэглэдэг болох

Судалгаанд оролцогчдын 38.4% (1498) нь цагаан сар, 25.2% (983) нь үндэсний их баяр наадам, 15.3% (595) нь найр хурим, 12.9% (502) нь тэмдэглэлт өдрүүдээр, 5.5% (216) нь өдөр тутам, 2.2% (86) нь хурал чуулган, уулзалтын үеэр, 0.5% (20) нь бусад гэж хариулсан байна.



Зураг 6.25. Цагаан сарын тэмдэглэх нь чухал эсэх

Судалгаанд оролцогчдын 90.9% (1960) нь тийм, 6.2% (134) нь хариулаагүй, 2.9% (63) нь үгүй гэж хариулсан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

1. Алсын хараа -2050
2. "Бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх онол, практикийн асуудал", 2019 Эрхэмтөгс Ж,
3. Бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн үнэлгээ, төлөвлөлтийн арга зүй, 2019, Эрхэмтөгс Ж
4. Дэлхийн Монголчууд хөтөлбөр
5. "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөр
6. Контентыг дэмжих хөтөлбөр
7. Кино урлагийг дэмжих тухай хууль
8. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III
9. Монгол уран бүтээл үндэсний хөтөлбөр
10. Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр
11. "Монгол төрийн соёлын бодлогын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах арга" төслийн тайлан, БСШУСЯ, СУИС
12. "Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйл" судалгааны тайлан, СУИС
13. Монгол хэлний тухай хууль
14. Оюуны өмчийн тухай хууль
15. Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр
16. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын суурь судалгаа, СЯ, ММСГ
17. Соёлын өвийн үндэсний төв
18. "Соёлын бүтээлч үйлдвэрлэл 2021" хурлын эмхэтгэл, СУИС
19. "Соёл, урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" судалгааны тайлан, БСШУСЯ, СУИС
20. "Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөр
21. "Сонгодог урлаг-III" хөтөлбөр
22. "Соёл урлагийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх" хөтөлбөр
23. Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр
24. Соёлын тухай хууль
25. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого
26. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого
27. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөр
28. "Цахим засаглал" үндэсний хөтөлбөр
29. <http://hmc.mn/medee/v/6>